

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-44

1.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал 3-44

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
10 дугаар сарын 10-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 46 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Пүрэвдорж;
Тасалсан: Ж.Баярмаа, А.Ганбаатар, Т.Доржханд, Л.Мөнхбаатар,
Г.Уянгахишиг, О.Цогтгэрэл, Ө.Шижир, Д.Энхтуяа.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Хуралдаан 15 цаг 01 минутаас 15 цаг 32 минутад завсарлав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Хэрлэн, Б.Баярбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, С.Бямбацогт, Д.Амарбаясгалан, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ, Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир, огцруулах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Амарбаясгалан, Ерөнхий сайд Г.Занданшатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, А.Ариунзаяа, П.Сайнзориг, О.Саранчулуун, Г.Дамдинням, Х.Баасанжаргал, Э.Одбаяр, Д.Амарбаясгалан нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ажлын цаг дууссан тул хуралдааныг 18 цаг 03 минутад завсарлуулав./18:03/

Хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11 цаг 05 минутаас үргэлжлэв.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Н.Номтойбаяр нараас хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй тухай бичиг ирүүлснийг танилцуулав.

Мөн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийг хуралдаанд хүрэлцэн ирэхийг хүсэв.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул хуралдааныг 11 цаг 33 минутад өндөрлүүлэв./11:33/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 14 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 2025 оны 10 сарын 13 өдрийн 11 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 46 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: 10-ны 14 цагаас товлогдсон. Одоо 14 цаг 20 минут болж байна. Одоогийн байдлаар ирвэл зохих 32 гишүүнээс 9 гишүүн ирж, ирц 28,1 хувьтай байна. Одоогийн байдлаар Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Цэрэнпилийн Даваасүрэн, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Эрдэнэбилэгийн Одбаяр, Цэндийн Сандаг-Очир, Бадарчийн Хэрлэн гэсэн 9 гишүүн хүрэлцэн ирээд байгаа юм байна. Бусад хуралдаа ирээгүй байгаа Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд хуралдаа ирэхийг хүсэж байна. Байнгын хорооны хурлын дараа нэгдсэн чуулгантай байгаа учраас хурлаа цагтаа эхлүүлмээр байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд чуулгандаа хуралдаандаа ирье, дуудаарай. Одоогийн байдлаар 14 гишүүн ирсэн байна. Хуралдааны ирц 43,8 хувьтай байна. 34 минут, 35 минут өнгөрч байна цагаасаа. 16 цагаас нэгдсэн чуулган зарлагдсан байгаа. Ажлын албаныхан энэ ирээгүй гишүүд рүүгээ залга.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. 2025 оны 10 сарын 10-ны 14 цагаас товлогдсон Байнгын хорооны хуралдааны ирц ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн ирж, 59,4 хувийн ирцтэй байгаа учраас хуралдаанаа эхлэхэд бэлэн боллоо. Ирцийг танилцуулъя өнөөдрийн хуралдаанаас албан ёсоор Бөхчулууны Пүрэвдорж гишүүн өвчтэй байгаа. Тэгээд ирсэн гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн, Дашзэгвийн Амарбаясгалан, Аюушийн Ариунзаяа, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Цэрэнпилийн Даваасүрэн, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Эрдэнэбилэгийн Одбаяр, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Цэвэгдоржийн Туваан, Бадарчийн Хэрлэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн 16, 19 гишүүн одоогоор ирсэн байна.

Ирээгүй гишүүдийг танилцуулна. Батын Батбаатар гишүүн ирээгүй байна Иргэний Зориг ногоон нам, Жудагийн Баярмаа Ардчилсан намын гишүүн ирээгүй байна, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн Ардчилсан нам ирээгүй байна, Лувсаннъямын Гантөмөр гишүүн Ардчилсан нам ирээгүй байна, Тогмидын Доржханд гишүүн ХҮН намын төлөөлөл ирээгүй байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн Монгол Ардын нам төлөөлөл ирээгүй байна гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн Эвсэл ирээгүй байна, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн, Оюун-Эрдэнэ дарга ирсэн байна, ирцдээ ороорой дарга, Оюун-Эрдэнэ гишүүн орж ирж байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ХҮН нам ирээгүй байна, Одонгийн Цогтгэрэл гишүүн Ардчилсан нам орж ирээгүй байна, Өлзийхүүгийн Шижир гишүүн ирээгүй байна, Доржхандын Энхтуяа гишүүн Ардчилсан нам гэсэн гишүүд одоогоор ирээгүй байна. Ажлын албанаас ирээгүй гишүүд рүүгээ утасдаж холбогдоорой.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар нэг асуудал хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 54 гишүүдээс 2025 оны 10 сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан. Энэ асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцье. Нэг тодорхой тайлбар хэлье. Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн нэгд Улсын Их Хурлын гишүүдийн $\frac{1}{4}$ -ээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавивал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101.2-т Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдыг огцруулах саналыг хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан. Ажлын хэсэг байна уу? Ерөнхий сайд орж ирэх үү? Дуудуулаарай, гишүүдээс асуулт асуух байлгүй. Шууд явж байгаа даа. Байнгын хорооны хуралдаан нээлттэй яваа.

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай саналыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Эхлэх үү. Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн бид Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтад заасан бүрэн эрхийнхээ дагуу дараах үндэслэлээр Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг гаргаж байна. Микрофон хаачихлаа. Яах юм бэ, бараг үргэлжлүүлээд явах юм уу энэ чинь одоо.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн бид Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн нэг дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтад заасан бүрэн эрхийнхээ дагуу дараах үндэслэлээр Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг гаргаж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлнө гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 2 дахь заалтад Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч танилцуулсны үндсэн дээр томилж, чөлөөлж, огцруулна гэж тус тус заасан.

Гэтэл Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нь 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд мэдээлэл хийхдээ өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд, бүрэн эрхийнхээ дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаар нэр бүхий гишүүнийг, Улсын Их Хурлын гишүүнийг томиллоо гэж албан ёсоор мэдэгдэн, Засгийн газрын болон өөрийн албан ёсны цахим хуудастаа уг мэдээллийг нийтэлсэн. Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар

Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг шийдвэрлэхээс өмнө Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгч танилцах бүрэн эрхтэй байна. Нөгөө талаараа томилох, чөлөөлөх, огцруулах шийдвэр гаргахаасаа өмнө Улсын Их Хуралд болон Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулах үүргийг Үндсэн хуулиар Монгол Улсын Ерөнхий сайд хүлээлгэжээ. Үндсэн хуулийн аливаа, Үндсэн хууль хийгээд аливаа хуулийн үг, өгүүлбэр төдийгүй цэг, таслал нь хүртэл утгын нарийн уялдаатай. Үндсэн хуулийг жижгээр зөрчих, томоор зөрчих гэдэг ойлголт байдаггүй бөгөөд бүгд Үндсэн хуулийн зөрчилд хамаардаг.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн далдугаар зүйлд Монгол Улсын Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийтийн байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэсэн гэж заасныг Монгол Улсын Ерөнхий сайд баримталж ажиллах ёстойг зөрчсөн байна. Гэтэл Монгол Улсын Их Хуралд болон Ерөнхийлөгчид Хууль зүй, дотоод хэргийн сайдыг огцруулах асуудлыг болон Хууль зүй, дотоод хэргийн сайдыг шинээр томилох асуудлыг танилцуулаагүй байхдаа ийнхүү Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томиллоо гэж олон нийтэд албан ёсоор зарласан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан, Үндсэн хуулийн суурь зарчмыг хөндсөн, хууль дээдлэх зарчмыг зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

Засгийн газрын гишүүнийг томилж, огцруулахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид урьдчилан танилцуулах нь төрийн эрх мэдлийг, төрийн эрх мэдлийн салаа мөчир болох институт хоорондын харилцаа төдийгүй төрийн эрх мэдлийн хуваарилалт, төрийн эрх мэдэл хоорондын харилцан хяналт тэнцвэртэй байх зарчмыг хангаж байгаа явдал юм. Үүнийг үл ойшоон Ерөнхий сайд онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томиллоо гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх суурь зарчмын нэг болох төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг алдагдуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн Монголын ард түмэн төрийн үйл ажиллагаанд үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрх эдэлнэ гэснийг зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн, Засгийн газрын тэргүүн төрийн өндөр хариуцлагатай албан тушаалтны хувьд олон нийтэд зориулж албан мэдэгдэл хийхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртлээ хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэснийг, 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий сайд Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн хэн ч болов шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэснийг тус тус зөрчин, бусдын гэм бурууг тогтоосон агуулгатай мэдэгдэл хийснээрээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын шүүх эрх мэдлийг бүрэн халдсан шинжтэй төдийгүй Үндсэн хуульд ёс, хууль дээдлэх зарчмыг үгүйсгэж байна. Тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томиллоо гэсэн агуулгатай түүний мэдэгдэл нь Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалын эрхийг хэтрүүлсэн, шударга ёсны зарчмыг өөртөө ашигтай байдлаар сонгож ашигласан, Монгол Улсын Үндсэн, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын бүрэн эрхэд хамаарахгүй ажил үүргийг хариуцах шинжтэй байна.

Ерөнхий сайдын энэхүү үйлдэл нь парламентын засаглалтай Үндсэн хуульд ёсыг гажуудуулах, хүн биш хууль засагладаг байх нийгмийн хүсэл зоригийн эсрэг

жишиг болж үлдэх эрсдэлийг бий болголоо. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-д Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн нь гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажлыг эрхэлнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх үндсэн хүрээнийхээ ажлыг энэ хуулиар, тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна гэж заасантай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина гэж заасантай нийцэхгүй үйлдлийг гаргалаа.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдөр баталсан 55 дугаар тогтоолоор нүүрс, төмөр, хайлуур жоншны экспортлох аж ахуйн нэгж нь тухайн сардаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөхдөө бүтээгдэхүүний $\frac{1}{4}$ -ийг уул уурхайн биржээр арилжаалсан тохиолдолд экспортод гаргасан бүтээгдэхүүний Амнат ноогдуулах борлуулалтын үнэлгээг биржээр борлуулсан үнэлгээгээр буюу бага үнээр тооцуулахаар зохицуулжээ. Ингэснээрээ тодорхой этгээдэд давуу байдал үүсгэсэн, шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжсэн, далд эдийн засгийг дэмжсэн, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн харилцаанаас ухарсан шийдвэр болсон байна. Мөн энэхүү тогтоол нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Ашигт малтмалын хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон болон холбогдох бусад эрх зүйн акттай тус тус зөрчилдөж байна.

Үүнээс гадна улсын төсөвт мөн төрлийн бүтээгдэхүүний Амнат-аас төвлөрүүлэх орлогыг бууруулах нөхцөлийг бүрдүүлж, улс орны эдийн засагт хохиролтой шийдвэр болсон төдийгүй Төсвийн тухай хуулийн 6.2.5-д төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн жилийн төсвөөс хэрэгжүүлнэ гэснийг зөрчиж Засгийн газар тогтоолоо баталсан байна. Үндсэн хуульд зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийтийн байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ Үндсэн хуульд нийцсэн байвал зохино гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн далдугаар зүйлийн нэг дэх хэсгийг баримтлан Үндсэн хуульд ёсыг хамгаалж, төлөөллийн хууль тогтоох дээд байгууллага болох парламентын дархлааг бэхжүүлэх нь Монгол Улсын Их Хурлын гишүүдийн үүрэг юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүн бид Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох зохицуулалт болон Монгол Улсын Засгийн газрын тухай, Татварын ерөнхий тухай, Татварын ерөнхий хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж, Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтад заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг албан ёсоор тавьж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүнд баярлалаа. Сайнзориг гишүүний танилцуулсан танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүдийн нэрс авъя. Оюун-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бямбацогт гишүүнээр, Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар гишүүн орж ирсэн байна. Асуулт эхлэхээс өмнө хуралдааныг 20 минут түр завсарлуулж байна.

30 минут. Энэ хуралдаан нээлттэй явж байгаа биз дээ Тамгын газрынхан? Тэгээд яагаад энэ сэтгүүлчид ингээд Байнгын хорооны хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангахгүй ингээд орилж чарлаад байгаа юм. Тэр хэвлэлийн өрөөндөө тусгай сэтгүүлчдийн өрөө байгаа шүү дээ. Тэндээсээ мэдээллээ ав. Энд хаалттай юм ерөөсөө юу ч байхгүй, бүгд шууд дамжуулж байгаа учраас энд заавал сэтгүүлчдийг оруулах бололцоо боломж байхгүй. Тийм учраас сэтгүүлчид мэдээллээ авах уу, эсвэл доор сэтгүүлчдэд бэлдсэн тусгай өрөөнөөсөө мэдээллээ аваарай гэдгээ хэлээд, ойлгуулаадах даа.

Хуралдаан 15 цаг 01 минутаас 15 цаг 32 минутад түр завсарлав.

Завсарлах хугацаа дууссан байна, 30 минут болсон байна. Дарга нар орж ирээрэй, Байнгын хорооны гишүүд орж ирээрэй хуралдаандаа, завсарлах хугацаа дууссан байна. Байнгын хорооны гишүүдээ дууд. Сая ирцэд орсон байсан 19, одоо 22 гишүүн болсон байна хуралдааны ирц 68 хувьтай байгаа. Ирээгүй байгаа гишүүдийг дуудахыг хүсье. Доржханд гишүүн ирээгүй байна, Уянгахишиг гишүүн ирээгүй байна, Баярмаа гишүүн ирээгүй байна, Ганбаатар гишүүн ирээгүй байна, Пүрэвдорж гишүүн өвчтэй, Шижир гишүүн ирээгүй байна, Энхтуяа гишүүн ирээгүй байна, Одонгийн Цогтгэрэл гишүүн ирээгүй байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирээгүй байна дуудаарай, энэ дотор байгаа юм байна лээ шүү. Завсарлах хугацаа дууслаа. Хуралдаанаа эхэлье, асуулт хариултдаа оръё. 10 гишүүн асуулт асуухаар нэрсээ өгсөн байгаа.

Ерөнхий сайдын хүсэлтээр хуралдааныг түр завсарласан байгаа. Одоо завсарлах хугацаа 30 минут өгсөн, одоо дууслаа. Тийм учраас гишүүдийг хуралдаандаа орж ирэхийг хүсэж байна. Дарга нараа дуудаарай, завсарлах хугацаа дууссан. Занданшатар даргыг дуудъя. Энэ олон гишүүд Занданшатар даргаас голцуу асуух байлгүй бодвол. Тийм учраас дууд. Энэ чинь 16 цагаас нэгдсэн чуулган товлондчихоод байгаа шүү дээ. Завсарлах хугацаа дууссан байна. Амарбаясгалан дарга орж ирсэн байна. Занданшатар даргыг дуудаарай. Байнгын хорооны гишүүд хуралдаа орж ирээрэй, хурлаа эхэлье, үргэлжлүүлъя. Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар дарга орж ирсэн байна. Хурлаа үргэлжлүүлъя гишүүдээ. Байнгын хорооны орж ирээгүй байгаа гишүүд орж ирье.

Асуулт, хариулт үргэлжилнэ. Нэрс авч дууссан. Энэ хэний нэр дутуу байна, Бат-Эрдэнэ гишүүний нэр гарчихсан байна, нэмж оруулаарай. Асуулт Ариунзаяа гишүүнээс эхэлнэ. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье. Ариунзаяа гишүүний микрофон.

А.Ариунзаяа: Занданшатар даргаа яагаад намын зовлонг төрийн зовлон болгочхов? Манай Бүлгийн гишүүд хүртэл юунаас болж ийм асуудал үүссэнийг бүүр мартчихсан байна лээ шүү дээ. Намын даргын сонгууль болсон юм шиг байна лээ шүү дээ уг нь, бага хурал хуралдсан юм. Тал бүрдээ хүмүүсээ оруулсан тооллогын комиссоо гаргаад, тооллогын дүрмээ тохироод, бүгдээрээ батлаад, шөнөжин бөөн юм болж байж муур, хулгана болж тоглоод бүр тэгээд уг нь нэг тал нь л ялсан юм билээ. Хэрэвзээ та 56 хувийн ялалтыг байгуулаад, хамтдаа баталсан дүрмийнхээ дагуу дараагийн шатны сонгууль нь болоод 2/3-оо аваад, өнөөдөр намын даргаараа бүртгүүлэх гээд явж байсан ийм асуудал өнөөдөр яг болох уу? Ийм л асуултыг би дотроо бодон, бодон өнөөдөр манай энэ төрийн зовлон юу болчхов гэхлээр ердөөсөө л энэ намын даргын суудлаас боллоо. Та ялагдчихаад тахимаа өгч чадахгүй, өрсөлдөгчөө хүнээр дамжуулан болон өөрөө хулгайчаар нь дуудаж,

шүүхээр тогтоогдоогүй хэргийг өөрөө шийдсэн мэтээр зарлаж явж байгаа нь хэр зохистой вэ Занданшатар даргаа?

Би таныг хүндэлдэг. Та Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхад би Улсын Их Хурлын харьяа байгууллагын даргаар Статистикийн хорооны даргаар ажиллаж бид хамтдаа маш олон ажлуудыг хийсний дотор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт. Харамсалтай байна, өдий олон албан тушаалууд дээр байж, өдий олон төрийн ажил албыг хийчхээд, тэгээд намын даргын сонгуулиас болж та ард түмэндээ хандаж мэдэгдэл хийнэ гэдэг зарыг авахад миний хувьд би таныг сайхан өрсөлдлөө, ялагдлаа, улс орны нөхцөл байдал хүнд байна, төсвөө баталъя, хамтарч ажиллая гэх болов уу гэж бодсон. Гэтэл та, тийм ээ чи хулгайч байна.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тодруулга тодруулга дээрээ авъя 1 минутаа. Ариунзаяа гишүүний асуултад Ерөнхий сайд Занданшатар дарга 5 номерын микрофон. Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье. Юуны өмнө би нэг зүйлийг тодруулъя. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу ч тэр Ерөнхий сайд завсарлага аваагүй болохыг мэдэгдье. Ерөнхий сайд завсарлага авдаг субъект биш 1-д.

2-т энэ намын байгуулалтын хэлтэс биш Ариунзаяа гишүүнээ, Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа гэж ойлгож байгаа. Та Тусгаар тогтнолын ордонд биш, Төрийн ордонд байна. Намын асуудлыг Төрийн ордонд хэлэлцэх ёсгүй. Би анхнаасаа Улсын Ерөнхий сайдын хувьд улс төр биш урдах ажлаа хийх, намын хэрэг намдаа, төрийн хэрэг төрдөө гэсэн зарчмыг барьж, Засгийн газрын индрийг огт ашиглаж байгаагүй. Би нүүрсний хулгай, дээрмийг таслан зогсоох тухай төрийн асуудал ярьж байсан, 100 хоног эхлэхэд анхнаасаа би 115 хоногийн өмнө энэ асуудлыг ярьж байсан. Гэмт хэрэгтэй тэмцэх нь Засгийн газрын үндсэн үүрэг, Үндсэн хуулиар хүлээсэн эрх үүрэг нь. Тийм учраас намын даргын асуудлыг энд ярих нь зохисгүй.

Харин би хуулийн асуудлыг тодруулж хэлье. Бидний хийсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу улс төрийн нам дотоод ардчилалтай, зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байх тухай Үндсэн хуулийн заалтыг оруулсан. Бодлогын нам байх зарчмыг Үндсэн хуульчилсан. Үүний дагуу Улс төрийн намын тухай хууль батлагдсан. Улс төрийн намын эрх барих дээд байгууллага бол намын Их хурал. Намын Их хурлаас намын даргаа сонгоно гээд заачихсан. Намын даргын орон гарвал намын бага хурлаар нийт гишүүдийнхээ 2/3-оор намын даргыг сонгоно гээд намын дүрэмдээ хуульчилчихсан. Энэ зөвшилцлөөр буюу нийт олонхын саналыг намын Их хуралтай дүйцүүлж олонхын саналаар шийдэхгүй гэсэн ийм зарчим бол намын дотоод ардчиллын үндсэн суурь зарчим гэж Улс төрийн намын тухай хууль болон дүрмээр заасан. Хууль хэрэгжүүлэх нь бүх хүний үүрэг. Хууль дээдлэх ёс зарчим.

Ийм учраас намын асуудлаа намын цагаан байрандаа ярьцгаая. Бид Засгийн газрын тэргүүний хувьд төрийн хэргийг, эдийн засгийг сэргээх асуудлыг энэ 100 хоногийн хугацаанд эдийн засгаа яаж сэргээж, багш, эмч нарынхаа цалинг яаж нэмэгдүүлэх вэ, энэ унаж байгаа эдийн засгийг яаж босгох вэ, бүх асуудал ярихад энэ маань эцэстээ бүгд л энэ нүүрсээ, нүүрсний экспортоо яаж нэмэгдүүлэх вэ, тэнд

байгаа нүүрсний хулгайг яаж таслан зогсоохтой л холбогддог. Энэ асуудал бол зөвхөн улс төрийн асуудал биш, хууль эрх зүйн асуудал. Ийм л сонголтын өмнө би ирчихсэн байгаа гэдгээ тодруулж хэлье.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Ариунзаяа гишүүн тодруулга 1 минут. Ариунзаяа гишүүний микрофон.

А.Ариунзаяа: Тийм ээ, энэ бол ердөөсөө төрийн тайз болохоос биш намын тайз биш. Би санал нэг. Гэтэл та намын зовлонг төрийн зовлон болгосон байхгүй юу. Та ялагдсанахаа маргааш нь мэдэгдлээ хийхдээ намын сонгууль болсон улс төржилтөө орхиё.../үг тасрав/

Ц.Сандаг-Очир: Алив энэ Улсын Их Хурал Тамгын газрынхан энэ тоног төхөөрөмжүүд чинь яагаад гацаад, тасалдаад.

А.Ариунзаяа: Намын өрсөлдөөнөө хойш нь тавих ёстой атал та бол Үндсэн хуулийг зөрчсөн мэдэгдэл хийсэн байхгүй юу та. Тийм ч хулгайч байна, Хууль зүйн сайдыг би өөрчилж байна, өөрчлөн томилж байна гэдэг ийм асуудлыг та өөрөө эхэлж ярьсан. Хэрэг эрхлэхийн сайд нь ч мэдээгүй, Бямбацогт сайд тухайн үед би мэдээгүй гэдгийгээ ч хэлж байсан хэвлэлээр гарсан. Бид чин шударга үнэнч байх ёстой. Нүүрсний сонсгол хэзээ явагдсан юм бэ? Таны энэ оффтейк гэрээнүүдийг ил болгосон гэсэн асуудал чинь та Улсын Их Хурлын даргаар ажиллаж байсан үеийн л асуудлууд шүү дээ. Тэрнээс өмнө та Хэрэг эрхлэхийн сайд байсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр нууцад оруулсан шийдвэрүүд нь яагаад ил болохгүй байгаа юм бэ? Намын зовлонгоо төрийн зовлон болгодог нь буруу байхгүй юу даа.

Энхбаярыг шууд Хууль зүйн сайдаар томилж байна гэдэг мэдэгдэл чинь өөрөө Үндсэн хуулийг зөрчихүйц ийм мэдэгдэл байсан. Гэхдээ үйлдэл дээр Хэрэг эрхлэх эрх биш нэг хуульч хүмүүс байна даа, процессын хувьд арай ч нэг зөрчил үүсгээгүй байх, маш харамсалтай. Анхнаасаа л төсвийн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Та бүхэн намайг 115 хоногийн өмнө 92,3 хувийн саналаар дэмжиж, Ерөнхий сайдаар томилсон. Монгол Улсын Ерөнхий сайдын Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын гишүүнээ томилж, чөлөөлөх бүрэн эрхийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр олгосон. Энд ямар ч Үндсэн хуулийн зөрчил байхгүй. Үндсэн хууль зөрчсөн эсэхийг та тодорхойлдог хүн биш. Та харин намын зовлонг төрийн зовлон болгоод Засгийн газрыг огцруулах, 115 хоногийн өмнө байгуулагдсан Засгийн газрыг огцруулах асуудлыг төрийн зовлон болгож өнөөдөр хэлэлцүүлж байгаа нь харин намын зовлон төрийн зовлон болгож байгаагийн жинхэнэ тод илрэл болж байна. Бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрыг тогтвортой ажиллуулахын тулд Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд томилж, чөлөөлөх бүрэн эрхийг олгосон. Тэр хүрээнд хийгдсэн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Дараагийн гишүүн Хэрлэн гишүүн асуултаа асууя.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр 6 сарын 12-ны өдөр одоогоос бүр 4 сар ч болоогүй байна 92 хувийн 118 хүн хуралд гишүүн оролцсоноос 108 хүн нь дэмжиж, энэ Ерөнхий сайдыг томилсон байдаг, энэ Засгийн газрыг

бүрдүүлэх эрхийг нь олгосон байдаг. Тэгээд 4 сар хүрэхгүй хугацаанд эргээд буцаагаад огцруулах тухай яриад сууж байна л даа. Тэгээд өнөөдөр энэ асуудлыг хэлэлцэнэ гээд тэгэхээр нь Төрийн байгуулалтын байнгын хорооноос Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийг баримтлаад хэлэлцэх гэж байгаа асуудлын талаар танилцъя, материалыг нь авч үзье гэсэн ийм хүсэлт тавьсан. Уг нь бид энэ Засгийн газрыг огцруулах тухай шийдвэрийг гаргахдаа нэлээн ултай суурьтай хандмаар байгаа юм.

Сая хурал дээр тарааж байгаа материалаас харахад 3 үндэслэл энд яригдаж байна л даа. Нэгдүгээрх нь болоод ирэхээр Хууль зүйн сайдын томилгоотой холбоотой. Ерөнхий сайд яагаад бүрэн эрхээ хэрэгжүүлж болохгүй болчихоод байгаа юм бэ хуулиар олгогдсон бүрэн эрхээ. Хоёрдугаарх асуудал нь болоод ирэхээр тэр юуны тухай хууль, 3 дахь нь болохоор Амнат-ийн тухай, 2 дахь нь болохоор хүн гүтгэсэн гэсэн ийм 3 асуудлыг гаргаж ирээд тавьж байна. Бид уг нь зүй нь ийм чухал асуудлыг хэлэлцэх гэж байгаа юм чинь энэ Төрийн байгуулалтын байнгын хороогоор нэлээн ултай суурьтай, судалгаа үндэслэлтэйгээр ярилцаж байж, үнэн зөвийг нь тогтоож шийдвэрээ гаргадаг баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр хууль зохион, энэ хурал зохион байгуулж байгаа энэ Тамгын газрынханд хандаж хэлэхэд энэ Дэгийн тухай хуулийг бид хэлбэрийнх нь хувьд хараад, хуулийн төсөл гэж хараад явах юм уу, эсвэл Улсын Их Хурлаас гарч байгаа бүх шийдвэр агуулга мөн чанараараа угтаа цаанаа шийдвэр шүү дээ энэ чинь, бүгдээрээ агуулгын хувьд нэг л зүйл байхгүй юу. Аливаа шийдвэрийг хэлэлцэхийн өмнө гишүүд энийг танилцсан байх ёстой гэсэн энэ утгаар бид энийг ойлгож явах юм уу энийг нэг тодорхой болгооч гэж хэлмээр байна.

2 дугаарт нь би Ерөнхий сайдаас хандаж нэг асуух зүйл байна. Өнөөдөр гадаа эмч нар, багш нар жагсаад байж байна л даа цалин хөлсөө нэмье гээд. Цалинг нь нэмье гэхээр ямар татварыг нь нэмэлтэй нь биш дээ, уул уурхай, байгалийн баялгаа ашиглаад олж байгаа орлогоо нэмэгдүүлчихье дээ, энд яригдаад байгаа хулгайнуудыг нь цэгцэлчихье дээ гэж бодоод та уг нь сүүлийн үед нэлээн эрчимтэй ажиллаад байх шиг байгаа юм. Ялангуяа одоо чинь бараг их наядаар нь ярьдаг болсон энэ хулгайтай яг тэмцэх гэж байгаа үед энэ асуудал босоод ирснийг та ер нь яг юу гэж харж байгаа юм бэ? Нийгэм өнөөдөр харж байгаа шүү дээ. Энэ Байнгын хорооны хурал, Их Хурлын хурал аль талдаа шийдвэр нь гарах нь вэ гэж харж хүлээж байгаа. Хулгайг дэмжсэн шийдвэр гаргах нь уу, эсвэл хулгайтай тэмцэж байгаа хүмүүсийг дэмжсэн шийдвэр гаргах нь уу гэж ерөнхийдөө харж байгаа. Та энэ талаар ямар байр суурьтай байгаа юм бэ?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Хэрлэн гишүүний, Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Ер нь Монгол Улсын Засгийн газрын энэ гарааны 3 сар бол эдийн засгаа өөд нь татаж, эх оронд нүүрлээд байгаа энэ эдийн засгийн уналтаас сэргийлэхийн тулд энэ баялгийн хулгайтай тэмцэх, түүнийг цэгцэлж, сэргээсэн ийм өдрүүд байлаа. Ганцхан жишээ хэлбэ би. Эрдэнэс Тавантолгой компанид 7 дугаар сарын 9-нд онцгой дэглэм тогтоосноос хойш сарын 1,7 сая тонноос экспорт 2,7 сая тонн болж сая саяар өслөө. Валютын нөөц түүхэн дээд хэмжээндээ хүрч, 5,9 тэрбум долларт хүрлээ. Ингэснээрээ бид эдийн засгаа сэргээж, валютын ханшийн өсөлтийг 4 мянгад хүрэх долларын ханшийг, инфляцыг 2 оронтой тоо руу алдах эрсдэлээс урьдчилан сэргийлж чадсан.

Хэнд, хэзээ, хэдээр борлуулж байгаа нь ил тод Биржийн гэрээтэй арилжаа 8,1 дахин өслөө. Ийм учраас энэ бол бодитой энэ хулгайтай тэмцэж, Таван толгойд онцгой дэглэм тогтоож, сар бүр алдагдалтай гарч байсан улсын төсөв 8 дугаар сард тодорхой ашигтай гарч, экспортын орлого 2 сард 513,8 сая доллар болж өссөн, үүний үр дүнд валютын нөөц 5,9 тэрбум доллар болсон ийм эдийн засгийн бодит тоогоор энэ батлагдаж байгаа. Манай Засгийн газар сайн ажиллаж байсан байна. Энэ Засгийн газар унагаах гэж байгаа, огцруулах гэж байгаа үндэслэлийг хайгаад олоогүй сүүлийн 3 хоног. Эдийн засаг огцруулахад хүнд, эдийн засаг ийм хүнд байх үед Засгийн газар огцруулах үндэслэлтэй шалтгаан гарах ёстой. Энэ бичиг хэдэн удаа толгой нь солигдсон, хэдэн удаа гишүүд шаардсан, энэ бичигтэй чинь бид танилцаж байж энэ хариуг нь өгөх ёстой шүү дээ. Өнөөдөр л харж байна. Ийм учраас тодорхой эзэнтэй, тодорхой асуудлууд ярихад бэлэн байгаа.

Ийм учраас асуудлуудыг үнэн бодитой, эдийн засгийн үндэслэлтэй хэлэлцэж, өнөөдөр хүртэл гацааж хүртээгүй ноогдол ашиг, алдагдсан боломжуудыг ил тод болгож, багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх бодит боломжуудыг эрэлхийлэх нь энэ бүх шатанд байгаа хулгайтай тэмцэж байж улс орны эдийн засаг сэргэх юм билээ. Ийм л ажлуудыг хийсэн. Энэ намын их хурал, бага хуралтай ч хамаагүй. Энэ бол Засгийн газрын хуулиар хүлээсэн үүрэг нь. Засгийн газар хуулиар хүлээсэн үүргээ тууштай хэрэгжүүлж байгаа.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн огцруулах үндэслэл, тодруулгыг өгнө. Таны асуултад л хариулж байна. Өргөн барьсан хүн Сайнзориг гишүүний микрофон. Сайнзориг гишүүний микрофон. Уучлаарай энэ доор Төрийн ордны юун дээр энэ сүлжээн дээр асуудал үүсээд, ингээд сүлжээ орж, гараад байгаа гээд, жоохон гацаатай байгаа юм байна. Тэрийг гишүүд зөвөөр ойлгоорой. Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Би Хэрлэн гишүүний асуултад тодруулж хариулъя. Ерөнхий сайд хэнийг кабинетдаа авч ажиллуулах асуудал дээр бид яриагүй. Энэ бол процессын маш том алдаа гарсан. Бид хэд 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийж байхдаа Ерөнхий сайд санал болгосны дагуу кабинетын гишүүн нэг бүрчлэн томилж, чөлөөлдөг байсан бол энийгээ зохимжгүй юм гээд Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Ерөнхий сайдаа кабинетаа бүрдүүл гэдэг эрхийг нь өгсөн. Тэгэхдээ нөхцөлтэй. Энэ нь Монгол Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчид танилцуулснаар гэж үг байгаа. Энэ танилцуулснаар гэдэг бол том утгын агуулга шүү. Энэ өөрөө эргээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт, Улсны Их Хурал буюу хууль тогтоох төрийн эрх барих дээд институт мэдээлэлтэй байж байж бас тодорхой энэ процессууд явна гэсэн үг. Урьдчилан танилцуулах үүрэгтэй Ерөнхий сайдын хувьд.

Ерөнхийлөгчийн институт болон Улсын Их Хурал танилцах бүрэн эрхтэй байхгүй юу. Үүнийхээ дараа хэнийгээ ч томилж болно. Тэгээд Ерөнхий сайд энэ дээр том алдаа буюу томиллоо гэдэг шийдвэр гарсан. Өөрийнхөө цахим болон Засгийн газрын албан ёсны пэйжээр гарсан. Энэ бол эргээд төрийн харилцан тэмцэл, эрх мэдлийн салаа мөчрүүдийн харилцан тэнцэл, хяналттай байх зарчмыг шууд үгүйсгэж байгаа байхгүй юу. Үндсэн хуулийн утга санааг жижгээр гуйвуулна гэж ойлголт байхгүй. Жижгээр зөрчнө гэж ойлголт байхгүй. Энэнийх нь дараа нөхөөд хийчихдэг юм гэдэг зүйл байхгүй. Энэ бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуульчид ч гэсэн өөрөө тэрийгээ хэлээд байлаа шүү дээ, одоо нөхөж гүйцэтгүүлнэ гээд. Тийм байж болдоггүй байхгүй юу даа. Энэ Үндсэн хуулийг чинь бид манах гэж энд сууж байгаа шүү дээ. Энэ Үндсэн хуулийг чинь дагаж мөрдөнө гэдэг тангараг

өргөсөн шүү дээ. Тэгээд бид хэд эндээс ухарч болохгүй л гэж зүйлийг хэлмээр байна.

Амнат-ийн асуудал байна. Уул уурхайгаасаа ухарчихсан. 2022 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг зараад 100 хувь амнат-аар зараарай гээд 23 оны 6 дугаар сарын 30-наас энэ хууль үйлчлээд эхэлсэн. Энэ хууль дээр асуудал байвал Улсын Их Хуралдаа хандаад, дагаж мөрдөх журмын зохицуулалт дээр магадгүй 25 байдаг юм уу, 26 онд 25, 30 хувиар зармаар байна, цаашдаа нэмэгдүүлээд ингээд цаашдаа 100 хувь хүрнэ гэдэг эрхээ авах ёстой юм. Ингэж юу гэдэг юм Улсын Их Хурал 100 хувь биржээр зар гэснийг 25 хувь зарж болно, энийгээ бүр сүүлдээ Амнат-ийг тооцох аргачлалтайгаа холбоод 25 хувийг зараад, 75 хувийг шууд болон биржийн бус арилжаагаар зарангуутаа тэр биржийн бус арилжаагаар зарсан хэсэг дээрээ биржээр зарснаар тооцуулж Амнат тооцоолж болно гээд. Энэ асар их хэмжээний улсын төсөвт орох ёстой орлогыг байхгүй болгочихсон шүү дээ.

Дэгийн, Засгийн газар дэгээ баталсан байна лээ. Дэгийн 6.2 дээр байна лээ. Сангийн төсөв, санхүүтэй холбоотой юм уу, Сангийн сайдын саналыг авч тусгана гэж үг байна лээ. Тусгаагүй байна лээ шүү дээ. Сангийн сайд нь энэ журмыг гаргаж болохгүй, улсын төсөвт ийм алдагдал гарах гээд байна, биржээс ухрах гээд байна, компаниуд цаашдаа нүүрсээ биржээр зарах энэ сэдлийг багасгах гээд байна гээд санал өгчхөөд байхад хүчиндэж батлаад хэдэн зуун тэрбум төгрөгийн улсын төсөвт орох ёстой орлогыг ингээд байхгүй болгочихсон. Тэгээд энийгээ ингээд буруу тайлбарладаг. Маш их хэмжээний хуулиуд, энэ Үндэсний баялгийн сангаар оролдож байгаа эд шүү, Үндсэн хуулийн 6.2-оор оролдож байгаа эд шүү. Тэгэхээр бид хэд энэ дээр нэг жоохон бодитой хандах ёстой юм. Би нэг хүнтэй зууралдаад байгаа биш, энэ чинь Үндсэн хуулийн үзэл санаа зохицуулалт болгоныг бид хэд хамгаалж ярих ёстой юм.

Засгийн газар бол хууль биелүүлдэг институт. Тэрнээс хуулийг зөрчиж ингэж шийдвэр гаргачхаад, араас нь олон тайлбарууд хэлээд байж болдоггүй байхгүй юу даа. Тэгэхээр энэ зүйлүүдийг бид хэд ойлгох ёстой юм. Тэгээд ер нь зүгээр яах вэ Ерөнхий сайдын бас нэг том үйлдэл бий. Шударга ёсны буюу илд бамбай болох гэдэг юм уу байж болох боловч хүний илд бамбай болж болохгүй. Энэ манай хуучин нийгэмд байсан юм. Ерөнхийдөө тодорхой хүнийг илд бамбай болгоно гэж байгаа юм. Нөгөө хүн бол асар хүнд юм хийж байгаа шүү дээ. Хүнийг гүтгэж байгаа. Хүнийг гүтгэж байгаа хүн дээр эрх мэдэл өгвөл дараа нь юу болох юм бэ. Энэ хэлмэгдүүлэлт болно, энэ хуулийн завхрал болно. Энэ Үндсэн хуульт ёс руу, парламент ёс руу халдах хэрэг болно. Тэгэхээр, өнөөдөр сая хүртэл хэлж байгаа байхгүй юу толгой нь солигдож байна гээд. Уучлаарай Ерөнхий сайдаа, миний албан бичиг толгой нь солигдоогүй шүү.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүн тодруулга 1 минут.

Б.Хэрлэн: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд ерөнхийдөө энэ Байнгын хорооны хуралдааныг хийхдээ, чуулганы хуралдааныг хийхдээ материалуудыг гишүүдэд хүргэсэн байх ёстой. Ингэснээрээ парламентын засаглалтай улс оронд заавал авч хэрэгжүүлдэг гол үндсэн зарчим болохыг олон нийтэд нээлттэй байх гэсэн энэ зарчмыг хангаж ажилладаг. Өнөөдөр сая ярьж байна тэр Амнат-ийн тухай ярьж байна. Энэ томилгооны тухай асуудлыг ярьж байна. Энийг яагаад бид өмнө нь энэ үндэслэлтэй юу, энэ гаргаж байгаа

асуудал нь үндэслэлтэй юү, үгүй юү гэдгийг бид шүүж хэлэлцэх, шалгаж үзэх ийм хугацаа бидэнд гаргаж өгсөнгүй. Яагаад энэ асуудлыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах энэ зарчмыг өнөөдөр үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ? Бид ямар ч үндэслэлгүйгээр магадгүй зүгээр ингээд сэтгэлийн хөдлөлд автаж магадгүй шийдвэр гаргаж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Баярбаатар гишүүн асуултаа асууя. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Хэд хэдэн асуулт байна. Өчигдрөөс эхлээд энэ цахим орчин чинь тэр чигээрээ энэ оффтейк гэрээ гэдэг нэг ийм баахан хүснэгтүүд гараад ирлээ. Тэгээд би энийг ч судлаад үзсэн энэ ч нэг өмнө нь ил болчихсон л зүйл байсан юм. Өчигдөр ч нэг их ил болоод явчихсан юм байхгүй л юм байна лээ. Би Ерөнхий сайдаас хэд хэдэн асуулт байна.

1 дүгээрт та хэдээс хэдэн оны хооронд Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан бэ? Мөн хэдээс хэдэн оны хооронд та Улсын Их Хурлын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүнээр байсан бэ? Та эсхүл Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаа ер нь суудаггүй байсан юм уу? Энэ оффтейк гэрээ гэдэг энэ хэдэн гэрээ чинь ил болсон юм шиг байна. Тэгээд 1 бодь групп гээд бас нэг тухайлсан субъектив хүмүүсийн нэр ус ингээд зураг хөрөгтэйгөө гараад яваад байна. Тэгээд энэ анх бол энэ төмөр замыг байгуулах шийдвэр хаана гарсан юм бэ, хэн гаргасан юм бэ, энэ төмөр замыг барих мөнгийг хаанаас олъё гэж ярьсан юм бэ, хэнээр хийлгэе гэж ярьсан юм бэ, хэн шийдсэн юм бэ? Тэгээд энэ шийдвэрийг яагаад нууцалсан юм бэ тэгвэл? Би тэр шийдвэрийг нууцаас гаргахыг шаардаж байна. Тэр нууцад оруулъя гэсэн шийдвэрийг хэн гаргасан юм бэ? Би Оюун-Эрдэнэ даргаас бас энийг асууя. Та 5 жил Ерөнхий сайдын хийсэн хүн, Үндэсний аюулгүйн зөвлөлийн гишүүн байсан хүн. Тэр нууцад оруулъя гэсэн шийдвэрийг хэн гаргасан тэр протоколыг би яг гаргамаар байна одоо.

Тэр хэдэн гэрээ яах вэ гарч болно, гэрээ бол гарч болно. Тэгэхээр энэ дээр энэ 19-өөс 20 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр л гаргаж эхэлсэн байгаа юм л даа. Би түүхийг нь аваад үзсэн л дээ. Тэгээд 19-өөс 22 оны хооронд л энэ оффтейк гэрээнүүд чинь хийгдсэн юм байна лээ. Тэр төмөр зам нь баригдсан мухар төмөр зам шүү дээ. Одоо тэр нь хэзээ холбогдох юм мэдэхгүй. Тэр 30 хэдэн гэрээ байгаа юм яг. Тэгэхээр би ер нь нэг ул суурьтай л ярьсан нь дээр хэдүүлээ одоо асуудлыг. Хэн энэ шийдвэрийг гаргасан бэ, хэн энэ шийдвэрийг нууцад оруулахыг гаргасан бэ, яагаад нууцад оруулсан бэ? Энэ асуултад би Занданшатар дарга, өмнөх Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ дарга хариулж өгнө үү гэдгийг би хэлмээр байна.

Тэгээд түрүүн та хэллээ 115 хоног их богинохон хугацаанд л даа. Хуулийг яаж гууль болгож, хууль биш хүн засагладгийг харлаа. Хууль сахиулах байгууллагыг улс төрийн байдлаар ашиглаж болдгийг харлаа. Баримттай л байх хэрэгтэй л дээ. Энэ Монгол Улсын Засгийн газрын энэ 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн энэ 55 дугаар тогтоол. Энэ Амнат-ийн асуудал, энэ хууль зөрччихсөн л байна шүү дээ энэ чинь. Хууль зөрчсөнийг чи тогтоохгүй гэж хэлэх байх л даа. Тэгээд тогтоодог газар нь тэгээд тогтоох байлгүй. Тэгэхдээ энэ зөрччихсөн л байна шүү дээ. Яагаад бусдад ийм давуу байдал олгож байгаа юм бэ? Тэгээд энэ төсвийн алдагдлыг чинь хэн нөхөх вэ? Тэр 200 тэрбум гэж яриад байгаа.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүний асуултад эхлээд Занданшатар дарга хариулна. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Баярбаатар гишүүн төрийн түшээ хүн хуулиа сайн судлах хэрэгтэй. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл оффтейк гэрээ юм уу, гүйцэтгэх засаглалын шийдвэр гаргадаг субъект биш, зөвлөмж гаргадаг газар. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ямар ч оффтейкийн гэрээ байгууллага. Би л лав оффтейкийн гэрээ байгуулах нь битгий хэл барьж ч үзээгүй, уншиж үзээгүй, харж ч үзээгүй. Сая л ил тод болохоор нь би харж байна. Яг ийм хэл ам маргаан 23 оны нүүрсний жагсаалтын дараа гараад, Улсын Их Хурлын гишүүд нууцтай танилцах бүрэн эрхийнхээ хүрээнд танилцах чиглэл өгөгдөөд, яг ингэж ярьж байсан гишүүд уншиж үзээд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, зөвлөмжийг уншиж танилцаад, нууцын баталгаа гаргаж байгаад уншиж танилцаад тийм шийдвэр гаргаагүй юм байна, оффтейкийн гэрээ байгуул, нууцаар байгуул, яг ийм, ийм гэрээ гэдэг гэрээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр батлагдаж байгаагүй, харж байгаагүй. Улс үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд шаардлагатай томоохон бүтээн байгуулалтуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмжүүд гарч байсан байдаг.

Ийм учраас энэ зөвлөмжтэй Баярбаатар гишүүн нууцтай танилцах бүрэн эрхийнхээ хүрээнд үзээд танилцчих нь хэрэгтэй. Оффтейкийн гэрээ гэдэг бүгдийг нь ил тод болгож, ард түмний хяналтад оруулж байгаа болохоос биш, тэнд байгаа нарийн ширийнийг нь хууль хяналтын байгууллагууд тогтоох ёстой байх. Хууль зөрчсөн юм уу, үгүй юм уу, хэн, хаана, ямар шийдвэр гаргасан юм гэдгийг нь. Энэ шийдвэрүүд дандаа баримттай, нотолгоотой, ил тод болох ёстой. Тэгээд Номтойбаяр гишүүн шаардаад байсан шүү дээ. Үгүй ээ энэ нүүрийг нь үзүүлчхээд гэрээнүүд нь алга байна гээд л ил тод болгооч гээд л Засгийн газраас шаардаад байсан шүү дээ. Тэр хүсэлтийн дагуу л ил тод болгосон шүү дээ. Тийм албан бичгүүд хүртэл зөндөө ирсэн.

Амнат тооцох журам бол хууль зүйн үндэслэлтэй. Засгийн газрын 55 дугаар тогтоол бол Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Уул уурхайн биржийн тухай хуультай бүрэн нийцсэн. Үндсэн хуулийн зөрчил үүсгээгүй, Улсын Их Хурлын татвар тогтоох эрхэд халдаагүй. Ашигт малтмалын тухай хуулийн 47.14-д экспортын бүтээгдэхүүний үнийн эх сурвалжийг Засгийн газар нийтэд зарлана гэж заасан. Амнат-ийн хувийг тооцох, ноогдуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална гэж заасан. Засгийн газар хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд уг тогтоолыг гаргасан. Өмнөх засгийн газрууд ч гэсэн энэ амнат тооцох журмыг 10 удаа өөрчилж байсан юм байна лээ. Тэр үед яагаад яригдаагүй юм бэ тэгвэл.

Харин бодит үр дүнгүүд чинь тэг болоод зогсчихсон байсан биржийн арилжаа сэргээд 8,1 дахин биржийн арилжаа өслөө. Энэ чинь бодит тоо шүү дээ. Дандаа амнаас шууд гэрээгээр борлуулагдаж байсан юмнууд таслан зогсоогдоод, биржээр зарагддаг болсон. Биржийн арилжааны үнэ өссөн, үүний чинь үр дүнд экспортын орлого нэмэгдсэн.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүний асуултад Оюун-Эрдэнэ гишүүн хариулна. Оюун-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Би уг нь дуугай л яваад байсан юм. Тэгээд өнөөдөр ил тод ярилцах цаг нь болж байх шиг байна. Тэгээд уг нь Монгол Ардын нам 2024 оны

сонгуульд дэлхий дээр ганцаархнаа олонхын санал авсан, 50 дээр нэмэх нь нэг. Өөр ийм эрх баригч хүчин байгаагүй. Уг нь бид мөрийн хөтөлбөрөө л биелүүлэхэд анхаарах ёстой байсан. Харамсалтай нь ингээд сандал суудлын хамтарсан засгаа тараагаад, ингээд асуудлууд өрнөсөөр, одоо ингээд аль нь үнэн, аль нь худлаа нь ч мэдэгдэхгүй, олон улсын хувьд ч, олон нийтийн хувьд ч онигоотой байдалд орж байна, харамсаж байна. Монгол Улсын л цаг явж байгаа. Би энийг өмнөх чуулган дээр зөндөө л уг нь хэлж байсан.

Өнөөдөр би нэлээн материалуудтай ирсэн байгаа. Ийм ч зүйл болох болов уу гэж бодсон юм. Тийм учраас та бүхэн надаас ч гэсэн үндэслэлтэй энэ шийдвэрүүдийг асууж болно. Төрийн ажил бол Үндсэн хуулийн дагуу баримтад тулгуурлаж ярих ёстой болохоос биш ямар нэгэн байдлаар цуу яриа эсвэл огт худлаа ийм мэдээлэлд цахим ертөнцөөр дамжуулж бие биеэ харлуулах ийм байдлаар явж болохгүй. Монголын ард түмэн ч гэсэн тролл армия даваад, бодитой дүгнэлтийг харах цаг болсон. Би нэг хэд хэдэн зүйл сануулъя. Энэ нүүрсний оффтейктой холбоотой энэ асуудал ер нь анх яагаад үүссэн бэ гэхээр 2022 онд төлбөрийн тэнцэл 2,7 тэрбум болчихсон юм. Тухайн үед Эдийн засгийн хөгжлийн сайдаар Хүрэлбаатар сайд байсан. Манай Бямбацогт сайд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг хийгээд, тэр эрх зүйн хүрээнд анх удаа Монгол Улсад Эдийн засгийн хөгжлийн сайд томилогдсон. Тэр хуулийн дагуу.

Ингээд гааль дээр нүүрсний бүрдүүлэлт, экспорт байгаад байгаа мөртөө валют орж ирэхгүй байгаа энэ асуудлыг Хүрэлбаатар сайд анх олж харсан юм. Ингээд яасан бэ гэсэн чинь оффтейк буюу урьдчилан зарсан ийм нүүрснүүдийг гаргаад, валют орж ирж байгаа нүүрсээ гаргахгүй байгаа ийм асуудал үүсээд, ингээд валютын нөөц багасаж, ханш алдсан гэдэг дүгнэлтийг хийсэн. Ингээд энэ оффтейк гэрээнүүдийг 2022 онд ил болгосон. Өчигдрийн яригдаад байгаа зүйлүүдээс нэмж ил болсон зүйл юу ч байхгүй.

Дээрээс нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй холбоотой шийдвэр гардаг нь үнэн. Энэ юу вэ гэхлээр Тендерийн тухай хуульд энэ зөвлөмж хамаарахгүй гэдэг шийдвэрийг гаргадаг юм. Нэг үгээр хэлбэл шууд гэрээ хийх худалдан авалттай холбоотой асуудлыг тагнуулаас бичиг авахын тулд ийм зөвлөмж гаргадаг. Энэ нь өөрөө юу вэ гэхлээр шууд гэрээ хийгддэг. Тагнуул яах вэ гэхлээр энийг нууц гээд үзчихдэг. Тийм учраас энэ зөвлөмжийг ч гэсэн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн тодруулга 1 минут.

Б.Баярбаатар: Ерөнхий сайдаа би асуултдаа хариулт авах гээд байгаа юм. Би оффтейк гэрээг Үндэсний аюулгүйн зөвлөл байгуулсан гэж хэлээгүй шүү дээ. Байгуулах эрхийг нь хэн олгосон юм бэ л гэсэн. Дараа нь тэр нууцад авсан шийдвэрийг хэн гаргасан юм бэ, яагаад нууцад авах болсон юм бэ гэдэг 2 асуултад хариулсангүй. Мөн би танин мэдэхүйн шинжтэй нэг асуулт асуусан. Та хэдээс хэдэн оны хооронд Хэрэг эрхлэхийн даргаар ажилласан бэ, хэдээс хэдэн онд Улсын Их Хурлын даргаар ажилласан бэ? Тэр үед таны Их Хурлын даргаар ажиллаж байхад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн хэн, хэн байсан бэ? Тэгээд саяын таны хариултаас би үзэхэд ойлгочихлоо. Зөвлөмж дээр үндэслээд энэ гэрээнүүд явчихсан юм л гэж ойлголоо шүү. Та тэгээд хариулчихсан учраас. Зөвлөмж гаргасан, тэр зөвлөмж дээр үндэслээд энэ гэрээнүүд явсан юм гэж та хариуллаа. Тэгэхээр би саяын энэ асуусан асуултууддаа товч хариулт авчихмаар байна. Оюун-Эрдэнэ дарга ч гэсэн бас.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар дарга.

Г.Занданшатар: Баярбаатар гишүүнийг би ахиад хуулиа уншаад, хүний үгийг бүрэн ойлго, зөвлөмж дээр үндэслэж шийдвэр гаргадаг..., хууль үндэслэж шийдвэр гаргадаг. Хуулийн, хууль бол Тагнуулын ерөнхий газрын саналыг үндэслэж, Засгийн газар төрийн нууцад авах шийдвэр гардаг Төрийн ба албаны нууцын тухай хуулиар. Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурал гүйцэтгэх засаглалын ажил хийдэггүй. Үндсэн хуулийн дагуу энэ 3 эрх мэдлийн салаа мөчрийн хүрээнд хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл гэж 3 эрх мэдлийн хүрээнд асуудлууд шийдэгддэг. Ийм учраас маш тодорхой хар дээр цагаан дээр бичсэн хууль зүйн үндэслэлийн дагуу л энэ асуудал яригдана. Тэр зөвлөмжүүдтэй танилцах эрх нь танд нээлттэй байна. Миний энэ цаг, минут бага байгаа учраас миний ажилласан цагийг юун дээрээс харж болно л доо. Би 2019../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Бодийн энэ оффтейк гэрээ явж байх үед Занданшатар дарга Хэрэг эрхлэх газрын дарга байсан. Би Занданшатар даргаас ажлыг нь авсан. Энэ гэрээтэй холбоотой асуудлыг нүүрсний сонсгол дээр хамгийн их ярихаар Загийн хоолойтой холбоотой тэр нөгөө Норинкогийн тийм ээ Туваан сайд бол сайн мэдэх байх, тэр асуудал. Бодьтой холбоотой энэ 2 оффтейк буюу хамгийн том оффтейкээс болж валютын нөөц яаж багасаж байна вэ гэдгийг л нүүрсний сонсгол дээр ярих ийм зорилготой ажлын хэсэг байгуулагдаад Энхбаяр сайд ахалсан. Тэр нь Бодийг тойрч, тойрч байгаад сүүл рүүгээ Бортээг болж хувирсан. Энэ бодитой шүү. Бүх Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд нь ингээд байж байгаа. Тэгэхээр одоо энэ Бодитой холбоотой асуудлыг ярих цаг нь болсон. Занданшатар дарга өөрөө гаргаад тавьчихсан, одоо өөрөө өөрийнхөө хийсэн ажлыг хариулах цаг болсон. Яагаад өргөн царигаар тавьсан юм, өргөн царигаас болж өнөөдөр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Дараагийн гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Түрүүний 5 дахь өдөр би нэг хэвлэлийнхэнд нээлттэй мэдээлэл өгсөн. Ер нь энэ нүүрстэй холбоотой асуудлуудыг нээлттэй болгоё гээд. Тэгээд ул сууриар нь үзье л дээ гээд. Урд нь нүүрсний сонсгол хийгээд л байсан бол одоо тэр оффтейк гэрээтэй холбоотой нүүрсний сонсголыг хийе. Бүх асуудлуудаа нээлттэй болгоё. Тухайн үед хэн ажиллаж байсан юм энэ бүх зүйлүүдээ тодруулаад, тэр хүмүүсээсээ хариултыг нь аваад ингээд нэг ярилцъя гэсэн нэг ийм ярилцлагыг өгсөн. Тэгээд сая Баярбаатар гишүүн хэллээ. Ереөсөө энэ сошиал чинь тэр чигээрээ л баахан оффтейк гэрээ л болчихлоо шүү дээ. Урьд өмнө нь яагаад гаргаагүй юм тэрийгээ. Тэгэхээр энийгээ л ярья гэж байгаа юм хэдүүлээ. Тухайн үед нь хэн нь ажиллаж байсан юм, хэн нь ажиллаагүй байгаа билээ.

Би ганц, хоёр асуудлаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр танилцуулж байсны хувьд ор тас зүйл орж ирээд хэдэн хүнээр ингээд тас цохиулаад ингээд явчихдаггүй шүү дээ тэнд чинь ямар учиртай юм, ямар юутай юм, Тагнуулын төв газар нь юмаа танилцуулна, учрыг нь хэлнэ, тэгээд ийм учраас энийг тэр сая Оюун-Эрдэнэ гишүүний хэлдгээр Биржийн тухай хуульд, юуны тухай хуульд Тендерийн тухай хуульд оруулахгүйгээр явуулъя ч гэдэг юм уу, шууд гэрээ хийе ч гэдэг юм уу

энэ асуудлуудыг ингээд танилцуулдаг л даа. 2 дугаар асуудал ер нь тэгээд нүүрсний гэрээгээр хамгийн гол нь нүүрс тойрсон асуудлаар энэ хөгжиж буй орнууд нөгөө баялгийн хараал гэдэг чинь энэ шүү дээ. Энүүгээр бие биеийгээ ялладаг, энүүгээр бие биеийгээ унагадаг, энүүгээр бие биеийгээ улс төрийн карьерийг нь дуусгадаг. Тэгэхээр нэг мөр энийгээ л хэдүүлээ ярилцъя гэсэн юм.

2 дугаарт 2022 оны 12 сарын 23-нд бид Уул уурхайн биржийн тухай хууль баталсан. Та тэр үед байсан, өөрөө Их Хурлын дарга байсан. Энэ сая Сайнзориг гишүүн нэлээн тодорхой танилцууллаа шүү дээ. Бид тухайн үед яах гэж энэ Уул уурхайн биржийн тухай хуулийг баталсан юм. Хамгийн том баяр бол бид нүүрсний хулгайтай яг баталсныхаа ар дээр бид хэвлэлийн бага хурал хийгээд, үүнээс цааш нүүрсний хулгайг байхгүй болгож, бид биржээр нээлттэй тод зардаг боллоо гээд бид аль, аль талдаа л зарласан шүү дээ. Тэгээд энэ бол бид бүх уул уурхайтай холбоотой асуудлаа, бүтээгдэхүүнээ биржээр зардаг болъё. Цаашаа харж байгаад оффтейк гэрээ хийдэг ч юм уу, цаашаа харж байгаад хэн нэгэн уурхайн дарга нь цаашаа тамга тэмдгээ дараад ингээд гэрээ хийчихдэг, нууц гэрээ хийчихдэг ийм зүйлээсээ л бид зугтъя. Тийм болохоор бид бүх асуудлаа Уул уурхайн биржийн тухай хуулиар зохицуулъя гэдэг ийм л заалтыг бид оруулсан. Сая Сайнзориг нэлээн тодорхой уг нь танилцуулах шиг боллоо. Тэгээд хариултуудыг нэлээн тодорхой хариулт сая Оюун-Эрдэнэ гишүүн ч өгчихлөө. Тэгээд миний хувьд үг хэлж байгаа юм шүү.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Бид Төрийн байгуулалтын байнгын хороогоороо Монгол Улсын Засгийн газрыг огцруулах асуудлыг ярьж байна. Тэгэхээр би юуны өмнө Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлээс та бүхэнд эшилж хэлье гэж бодож байна. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж байна. Ингээд сүүлийн 100 хоног энэ ерөөсөө тэр чигээрээ уландаа гишгэгдэж байна. Уул нь 4 сар орчмын өмнө бид энэ Ерөнхий сайдыг, энэ Засгийн газрыг дуу нэгтэйгээр томилсон, бүгд итгэж дэмжсэн.

Гэвч өнгөрсөн 100 хоногийн ажлын хангалтгүй байдал, цаашлаад өнгөрсөн 10 хоног ерөөсөө бараг галзуурлын түвшинд очлоо. Та ард түмэндээ хандаж мэдэгдэл хийхдээ Хууль зүйн сайдыг онцгойлон нэг хүнийг яллахын тулд, бүүр яллахын тулд томилж байгаа гэдэг ийм мэдэгдлийг ил тод хэлсэн. Ерөнхий сайд мэдээж бүрэн эрхийнхээ хүрээнд хэнийг ч сайдаар томилж болно. Гэхдээ ийм зорилгоор хэзээ ч болохгүй. Бид олон асуудал ярьж байгаа учир энэ оффтейк, Амнат гээд эндээс жоохон анхаарал саараад байна л даа. Гэхдээ эрх зүйт Монгол Улсад аливаа нэг хүнийг яллах зорилгоор хонгилын түлхүүрийг гардуулж өгч болохгүй. Энэ ил болсон зүйл. Сүүлийн хоногуудад энэ ордон дотор далд болж байгаа зүйлийг бүгдээрээ нээлттэй ярилцъя. Засгийн газрын гишүүд энэ Улсын Их Хурлын гишүүдийг нэг нэгээр нь дарамталж байна, сүрдүүлж байна, компаниуд нь шалгалт оруулж байна, зөвшөөрлийг нь цуцална гэж байна, заримд нь сайхан бүр хүссэн болгоныг нь амлаж байна. Сандаг суудлаа авч үлдэхийн тулд. Ийм л зүйл өнөөдөр бодитоор болж байна.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганд хэдэн гишүүн ирэхгүй байхыг бүгдээрээ нүд цавчилгүй харах ёстой. Хэн хэнийг дарамталж сүрдүүлсэн байна, эсвэл хэн хэнтэй эрх ашгаа нэгдсэн байна гэдгийг бүгдээрээ бид анзаарах ёстой. Бидний үндсэн ажил чуулгандаа ирж саналаа өгөх. Бид ирээд дэмжинэ үү, үгүй юу хамаагүй бид саналаа өгөх ёстой. Бид тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүд. Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоноос хойш энэ үлгэр мэт яригдаад байдаг нөгөө хонгил гэх зүйлийн зах зухаас нь үзэж байна, харж байна, мэдэрч байна. Бид энэ байдлыг зогсоохгүй бол үнэхээр болохгүй нь. Өнөөдөр энэ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут.

Э.Болормаа: Өнөөдөр энэ Хууль зүйн сайдыг чөлөөлөх гэж байгаа ажил ерөөсөө цаашид юу болно гэхээр бид нэг өдөр энд сууж байна манай Лувсанжамц гишүүнийг, эсвэл Цэнгүүн гишүүнийг нэг өдөр зүгээр дураараа алуурчин, хулгайч гэж цоллоод, араас нь яллах хүмүүсийг явуулж болно л гэдэг энэ суурийг тавьж байна гэсэн үг. Энэ байдаг мэт манай ах нар яриад байна л даа. Ерөөсөө энийг тоосон шинжгүй, улс төр ийм хатуу шүү дээ, угаасаа байдаг шүү дээ гэж. Хэрвээ Улсын Их Хурлын гишүүдийг ингэж байгаа бол жирийн иргэдийг, аж ахуйн нэгжүүдийг яаж дарамталж болдог бол гэдгийг бүүр бодохоос айж байна. Тэгэхээр парламент Засгийн газрыг томилдог шүү, төрийн бүх эрх мэдэл ард түмэнд байдаг шүү гэдгийг та нар хэтэрхий мартаж байна. Хэт хүссэн хүнд төрийн жолоог бүү атгуул гэдэг үнэхээр үнэн үг байна. Энэ зүйлийг, энэ гажуудлыг арилгахын тулд би энэ Засгийн газар огцрох ёстой гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Болормаа гишүүн үг хэллээ. Бямбацогт гишүүн асуултаа асууя.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүнээс асуучихъя. Таныг болон энэ огцруулах саналыг өргөн барьсан, гарын үсэг зурсан гишүүдийг яг ямар, ямар хүмүүс, хэзээ, яаж дарамталсан бэ? Энэ дээр та нэг тодорхой хариулт өгөөч. Бид бодитой ярих ёстой. Яагаад гэвэл та огцруулах санал гаргачхаад, гаргасан саналаа Улсын Их Хурлын гишүүдийг танилцах бололцоо, боломж өгөхгүй, гэнэт сая оруулж ирээд, нэлээд 3 үндэслэлээр огцруулъя гэж байна л даа. Уул нь Улсын Их Хурлын гишүүд чинь яах гэж Үндсэн хуульд 3 хоногийн дараа, өргөн барьснаас хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэсэн бэ гэхээр Их Хурлын гишүүдийг танилцах, өөрийн итгэл үнэмшилтэй болох, судлах, мэдэх, иргэдэд мэдээлэх энэ бололцоо боломжийг хангах гэж л уул нь ингэж заасан юм л даа. Гэтэл нууж байгаад, хууль зөрчиж байгаад, гэнэтхэн тулгаад оруулж ирж байна. Энийгээ тайлбарлахдаа Их Хурлын гишүүдийг дарамтлаад, айлгаад, сүрдүүлээд байгаа учраас гэсэн байна. Яг ямар гишүүдийг, яаж, хэзээ, яаж дарамталсан бэ? Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч гэж.

2 дугаарт нь татвар бодитой байх ёстой, юу хийсвэр байх ёстой юу татвар. Төр оршиж байгаа бол татвар авах нь үнэн, орлого олж байгаа бол татвар төлөх нь үнэн. Гэхдээ төлж байгаа татвар нь бодитой байх ёстой гэж би боддог юм. Бодитой биш байсан учраас аж ахуйн нэгжүүд төлж чадахаа больчихсон. Үүнээсээ болоод Улсын дээд шүүх хүртэл маргаад, Дээд шүүх дээр хүртэл шийдвэр гараад тэр жонш дээр татварыг бодитой байлга, хийсвэр хэт өндөр зохиомол татвар авч байна гэдэг асуудал гарч байсан юм байна лээ. Үүнтэй холбоотойгоор Засгийн газар шийдвэр гаргасан. Түрүүн ярьсан урьд өмнөх Засгийн газар ч 10 удаа Амнат-тай холбоотой шийдвэр гаргаж байсан юм байна лээ. Энд яг ямар хууль зөрччихөв? Татварын хувь

хэмжээг Улсын Их Хурал тогтооно, Засгийн газар татварын хувь хэмжээг тогтоогоогүй. Татварыг хийсвэр үнээс биш, бодитой үнээс л авах тийм үү, зохиомол үнээс биш авах л ийм шийдвэр гаргасан. Энэ маань ямар хууль зөрчихөөд байгаа юм бэ?

Үүний үр дүнд улсын төсөвт зуугаад тэрбум төгрөгийн орлого орж байна, бодитой тооцоо хийгдсэн. Сангийн яам ийм учраас дэмжсэн. Сангийн яам дэмжсэн байхад нь дэмжээгүй гэж яриад байх шиг байгаа юм. Биржийн нүүрсний арилжаа 6 сард 132 мянган тонн болж буурсан байсан. Энэ шийдвэр гарснаас хойш 8 сард 740 мянга, 9 дүгээр сард 1,1 сая тонн биржээр арилжигдаж, өөрөөр хэлбэл татварын орлого нэмэгдэх, энэ хэмжээгээр Үндэсний баялгийн сан байгалийн баялгийн өгөөжөөс ард иргэд маань хүртэх бололцоо боломж нэмэгдсэн. Үүнийг яагаад хууль зөрчсөн гэж, ямар үндэслэлтэй тайлбарлаад байгаа вэ? Татвар бодитой байх ёстой юу, хийсвэр байх ёстой юу? Та энэ дээр нэг тодорхой хариулт өгөөрэй.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн, дараа нь Оюун-Эрдэнэ гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Сүүлийнхээс нь эхлээд хариулъя. Би Бямбацогт сайдтай хамтарч ажиллаж байсан, бас баримт ярьж байж ярих ёстой гэдэг зарчмыг уг нь танаас сурсан юм. Хуулийг биелүүлэх ёстой гэдгийг танаас сурч байсан. Харамсалтай нь та өнөөдөр надаас хуулийг зөрчсөн шийдвэрээ шал өөр байдлаар асууж байгаад харамсаж байна. Татвар бодитой байж болно, бодитой байлгах ёстой. Тэгэхдээ энийг хуулийн хүрээнд хийх ёстой. Таны батлалцсан буюу та өмнөх парламентад байсан. Энэ Биржийн хуулиар 100 хувь нүүрсийг биржээр зарах ёстой. Ялангуяа төрийн болон орон нутгийн өмчит компаниуд.

Стратегийн бүтээгдэхүүн болох жонш, төмөр, зэс, нүүрсийг биржээр заавал зар гэдгийг өмчийн хэлбэр үл харгалзаж байсан. Энийг зөрчөөд та нар 25 хувийг зарж болно. Бусдыг нь ямар нэгэн байдлаар зарж болно гэсэн. Энэ асуудал өөрөө шийдэгдэхийн тулд өнөөдөр парламентад оруулж ирээд, Биржийн хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт хэрэгтэй байна, тодорхой цаг хугацаанд 25, тэгээд энийг өсгөөд цаашдаа 100 хувь болгоно гэж парламентын бүрэн эрхэд халдахгүйгээр хийх бололцоо Засгийн газарт байсан. Улсын дээд шүүх энийг шийдвэр гаргасан өөрөөр гаргасан шүү, Захиргааны ерөнхий хуульд нийцээгүй учраас энэ журмаа шинэчилчхээч гэж гарахыг далимдуулж байгаад гаргасан. Энэ байж байгаа. Энэ хар даа, Адил Оч ХХК болон нэр бүхий 13 компани ингэж гуйвуулж болохгүй шүү.

Сая Ерөнхий сайд хэлж байна лээ. Эдийн засаг өсөлттэй байгаа гээд. Харамсалтай нь тийм биш байна лээ. Би 8 дугаар сарын статистик мэдээг аваад сууж байна. 8 дугаар сарын байдлаар 1 их наяд 247 тэрбум төгрөгийн төсөв алдагдалтай гарсан шүү. Та нар ингээд ард иргэдийг нэг ийм хэвлэл мэдээллийн бүх зүйлүүдийг монопол барьж байгаагийн хувьд тархийг нь угаачихна гэж бодоод байх шиг байна, үгүй л дээ.

Би дээрээс нь статистик үзүүлье. Та сая яг амнаасаа 1 сая нүүрсийг бид биржээр амжилттай зарлаа гэсэн боловч энэ хугацаанд энэ Амнат-ийг маш багаар тогтоож байгаад хугацаанд чинь бирж, нийт хилээр буюу экспортод гаргахаар 3,4 сая тонн нүүрсийг хийчихсэн байна. Энэ статистикуудыг би харуулж болно. Өөрөөр хэлбэл энэ Амнат-ийг зарж байгаад, гэрээн дээр нүүрс зарж байгаа юм. Дараа жил

бид бодит байдлаар нүүрс экспортолж чадахгүй. Яагаад гэхээр энэ оны энэ хууль зөрчсөн Амнат-ийн дагуу гаргаж байгаа ийм гэрээнд цаасан дээр зурагдсан нүүрснүүдийг чинь гаргах гэж энэ яг нөгөө өмнөх эдийн засгаа сүйрүүлдэг бодлого явж байгаа байхгүй юу. Одоо 7, 9 сард гэхэд 85 гэрээ байгуулагдаад, 3 сая 500 мянгыг зарсан байна. 1 саяыг нь та биржээр зарчхаад, үлдэгдлийг нь хаагуур зарчхав? Энийг чинь л бид яриад байгаа шүү дээ. Энэ Эрдэнэс Тавантолгойд үйлчилж байгаа, маш том хуулиуд зөрчигдөж байгаа. Энийг ингэж улаан, цагаан мэтгэж болохгүй. Өнөөдрийн байдлаар энэ биржээр үл ялиг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Оюун-Эрдэнэ дарга нэмэлт тайлбарыг хийж болно. Яагаад гэхээр Сайнзориг нарын санаачлах нь 54, 55 гишүүд гарын үсэг зурсан. Эд нар санаачлагч учраас хэн нь ч асуултад нэмэлт тайлбар хэлэх эрхтэй байгаа юм. Тийм учраас Оюун-Эрдэнэ даргад нэмэлт тайлбар өгөх энэ цагийг өгч байгаа. Тэрнээс хэн нэгэнд нэмж хариулт хэлэх, тайлбар давуу эрхээр олгож байгаа юм биш шүү гэдгийг хэлье. Оюун-Эрдэнэ дарга хариулт нэмэлт.

Л.Оюун-Эрдэнэ: Хамт ажиллаж байсан хүмүүс 100 хоног дотор учиргүй төрөл арилжаад л, харь гаргаас буугаад ирчихсэн, хиймэл оюун ухаантай ийм шинэ сервер болчихсон гэж би бол ерөөсөө бодохгүй байгаа. Одоо хэдүүлээ ингэж нэг тойрч худлаа яриад яах вэ. Энэ Амнат-тай холбоотой асуудлыг дандаа л Оожий захирал лоббиддог байсан юм, Оджаргал захирал. Уг нь манай Сангийн сайд Жавхлан ноён нуруугаа хугалчихгүйхэн шиг л над дээр орж ирээд л ийм дарамтад ороод байна, шахаад байна, байнга уулзаад байна, тэгээд уул нь ингээд гүрийгээд яваад байна л гэдэг байсан. Би зүгээр Жавхлан сайд энэ дээрээ байгаад саналаа өгөөгүй юм уу гэж ойлгосон түрүүн тэр нэг санал өгсөн, өгөөгүй гээд нэг тайлбар өгсөн юм байна лээ. Тэгэхээр одоо хэдүүлээ ингэж худлаа яриад яах вэ. Улсаасаа том нэг компанитай болчихсон улсынхаа нэрийг Эм Си Эс гэж өөрчилъе. Энийг миний хувьд Ерөнхий сайд.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Энийг үгүй л гээд явж байсан. Энэ нэг их тийм шинэ юм биш. Одоо яах вэ гэхлээр нэг компанид давуу тал олгосон ийм асуудлыг л шийдчихсэн гэсэн үг. Энийг нуугаад байх юм байхгүй шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт гишүүн тодруулъя, 1 минут.

С.Бямбацогт: Ашигт малтмалын тухай хуульд Сайнзориг гишүүнээ төрийн өмчит компаниуд заавал зарна, хувийн хэвшилд бол заавал зарах юм байхгүй байгаа. Энийг та ингэж мушгиж тайлбарлаж болохгүй байх. Сая тоо ярьж байна. 8 дугаар сард төсөв 52 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. Сая би бас тоо ярилаа, 132 мянга болж биржийн арилжаа буурсан байсан бол 9 сард 1,1 сая тонн болж 8 дахин өслөө биржээр. Урьд нь биржээр зарагддаггүй байсан бол энэ шийдвэртэй холбоотойгоор биржээр зарагдах тоо хэмжээ ингэж нэмэгдсэн байна. Энэ тоо ярьж байгаа шүү дээ бас. Энийг яачихъя.

Дээрээс нь нэг тодруулаад асуучихъя. Энэ Дэгийн тухай хууль зөрчигдөөд байгаа, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэгийн тухай хууль. Энийг хуралдаан даргалагч ямархуу байдлаар шийдэх вэ?

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя, тодруулгад нь хариулъя Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгье, тэгье. Ерөнхийдөө Бямбацогт сайдад би нэг хуулийн заалтыг уншиж өгье дөө. Уул уурхайн биржийн тухай хуулийн 10.2 дахь хэсэг гэж байдаг юм сайдаа. Энэ дээр орон, төрийн болон орон нутгийн өмчит болон орон, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд борлуулах асуудлыг бүр хатуу хуульчлаад, дээрээс нь стратегийн бүтээгдэхүүнийг зөвхөн биржээр зарах асуудлыг Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор баталчихсан юм. Та тогтоолоо нэг эргэж харна уу, эсвэл доод байгаа хүмүүсээсээ мэдээллүүдээ авах нь зүйтэй. Энүүгээр заавал зарагдах ёстой. 100 хувь зарагдах хуультай хуулийг та нар 25 болгоод, 25-аас нь сүүлдээ бүр амнат тооцож өгч байгаа шүү. Энэ Ганцмод-Гашуунсухайтын үнэ чинь бодитой үнэ биз дээ сайдаа? Хамгийн бидэнтэй хамар залгаад сууж байгаа ганцхан боомт шүү дээ. Энэ дээр чинь тонн нүүрс тээвэртэйгээ 135 байхад, манай бирж чинь 90 доллар байгаа шүү дээ. Тэгээд энэнээс 45 долларт нь хэн төлөх вэ? Тэгэхээр бид хэд асуудлуудыг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гарын үсэг зурсан учраас Амарбаясгалан дарга микрофоныг өгье, нэмэлт тайлбар өгье гэж байна.

Д.Амарбаясгалан: 22 оны 10 дугаар сард Засгийн газрын 362 дугаар тогтоол батлагдаж, энэ олон сая тонн нүүрснүүд хилээр гарсан мөртөө эргэж мөнгө нь орж ирэхгүй байгаа нөхцөл байдал үүссэн учраас Биржийн тухай хуулийг хэрэгжүүлж, төрийн өмчит компаниуд биржгүйгээр нүүрс арилжаалахыг хориглох шийдвэр албан ёсоор гарч байсан байдаг. Өнөөдөр энэ Сайнзориг нарын гишүүдийн энд санаачлаад биржээр зарагдаж байгаа нүүрснээс Амнат-ийг бүтэн авахтай холбоотой асуудал зайлшгүй хөндөгдөхөөс өөр аргагүй асуудал гэж харж байгаа. Би бол өнөөдөр талархалтай байгаа нэг зүйл нь жинхэнэ нүүрсний хулгайчдын сэжүүр цухуйж гарч ирж байгаад их талархалтай байгаа. Миний минут дуусаж байгаа учраас дараачийн минут дээр би энэ асуудлаар ярья гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт гишүүн 1 минут тодруулъя, сүүлийн тодруулга.

С.Бямбацогт: Би нөгөө түрүүн асуусан Их Хурлын гишүүдийг айлгаад, ичээгээд, дарамтлаад сүрдүүлээд байна гэдэг асуудал яригдсан. Яг ямар гишүүдийг нэрийг нь хэлж өгөхгүй юу, яаж дарамталсан бэ гэж?

2 дугаарт нь Үндсэн хуулийн, Үндсэн хуульд Засгийн газрыг огцруулах асуудлыг 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж заасан байгаа. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж заасан байгаа. Энэ 2 хуулийн зөрчлийг бид хэрхэн яаж шийдэх ёстой вэ? Зөрчилтэй байгаад байгаа юм. Тэгээд одоо 72 цаг болоогүй байхад өнөө өглөө 8:30-аас Байнгын хороо хуралдана гэж байгаад л хуралдаагүй. Мөн Хууль зүйн сайдыг Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхийлөгч танилцуулаад, Их Хуралд танилцуулах гээд ингээд танилцахад танилцуулдаггүй, хойшлуулчихдаг, тэр нь хууль зөрчигддөг. Ерөнхий сайд хууль зөрчөөгүй байж байхад Улсын Их Хурал дээр хууль зөрчөөд ингээд байгаад байгаа иймэрхүү асуудлаа бид хэрхэн, яаж шийдвэрлэх вэ? Энэ дээр Байнгын хорооны дарга тодорхой тайлбар өгөөч.

Ц.Сандаг-Очир: Эхлээд Сайнзориг гишүүн хариулчих. Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Бямбацогт сайдаа би яах вэ зүгээр хүний хувийн асуудалд нэг их халдахгүй. Тэгэхдээ маш олон баримтууд байгаа. Манай намын удирдлагад олон жил явсан ах нар ч байгаа, бүгд мэдэж байгаа. Дээрээс нь төрийн байгууллагуудын аппарат оролцож эхэлж байгаа. Ялангуяа хууль хяналт болон компани, аж ахуйн нэгж байгууллагуудыг шалгадаг энэ нууц биш. Дээрээс нь нэр бүхий компаниуд байгаа. Энэ Улсын Их Хурлын гишүүдийн хувийн хамааралтай компаниудад ажил олгосон компаниуд дарамталдаг юм байна лээ. Нууц биш, ах нь ажил амьдралгүй боллоо, эндээсээ ухарч байгаа шүү дээ. Ингэж та нар эрх мэдлийн төлөө улайрдаг юм байна лээ. Би шоконд ороод байгаа байхгүй юу. Гишүүд нь ярих байх.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуультай Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, заалтууд зөрчилдөж байгаа зүйл бий. Тэр нь таны сая асуусан Ерөнхий сайдыг огцруулах асуудал. Үндсэн хууль дээр 3 хоногийн дараагаас, өргөн баригдсанаас 3 хоногийн дараа хэлэлцээд, 10 хоногийн хугацаанд дуусгана гэж байгаа. Дэгийн хууль дээр 3 хоногийн дараа хэлэлцээд, 7 хоногийн хугацаанд хэлэлцэж дуусгана гэсэн, 7 хоногийн дараа. Ийм зөрчилтэй 2 заалт байгаа. Тийм учраас энийг манай Төрийн байгуулалтын байнгын хороо миний зүгээс ажлын албаныханд чиглэл өгөөд, хуулийн төсөл боловсруулаад явж байгаа. Энийг засаж залруулах чиглэлээр. Энэ дээр нэмэлт тайлбарыг Баасандорж дарга өгөөрэй Бямбацогт гишүүний асуулт дээр.

Энэ асуудлаар Цэц дээр маргаан үүсчихсэн явж байгаа яг бас. Миний бие итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр явж байгаа. Тэгэхээр энэ зөрчилтэй байгаа хуулийн зүйл, заалтуудыг засах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байна. Тийм учраас удахгүй хуулийн төслөө өргөн барьж, энэ Үндсэн хуультай зөрчилдөж байгаа Дэгийн тухай хуулийн холбогдох заалтуудыг нэмэлт, өөрчлөлтөөр засах асуудлууд орж ирнэ гэдгийг танд хэлчихье. Амарбаясгалан гишүүн асуултаа асууя.

Д.Амарбаясгалан: Би түрүүн хэлсэн. Өнөөдөр талархалтай байна. Яагаад гэхээр олон жилийн туршид нууцад дарагдаад, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр гэрээ хийх эрхийг олгуулаад, нэлээдгүй олон их наяд төгрөгийн нүүрсний гэрээтэй холбоотой асуудал энэ цаг өдрүүдэд яригдаж байгаад талархаж байгаа юм. 2022 оны нүүрсний сонсголын асуудал яг л энэнээс үүдэж эхэлж байсан. Харамсалтай нь эдгээр оффтейк гэрээнүүдийг бүгдийг нь нуугаад, бүгдийг нь далдалж байгаад, өнгөн дээр нь өөр хүмүүсийг нүүрсний хулгайч гэж зарлаж, нийгэмд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гүжирдэж гүтгэсэн. Тэрний хамгийн том хохирогч нь миний бие өөрөө байна. Нэг.../үг тасрав/, микрофон, нэг хүрз нүүрс олборлоогүй газрыг олборлож нүүрсний хулгай хийсэн мэтээр олон нийтэд ойлгуулсан. Өнөөдөр харин энэ оффтейк гэрээнүүд яаж хийгдэж, юу хийж, тэрийг нь хэн хариуцаж ажиллаж байсан бэ гэдэг зүйл нь цаг хугацаатайгаа тодорхой гарч ирж байгаад их баяртай байна.

Эдгээр оффтейк гэрээнүүд бүгд 2021 оны 6 сарын 23-ны өдрөөс өмнө хийгдсэн гэрээнүүд. Би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар 22 оны 9 сараас эхэлж ажиллаж байсан. Тэр үеэс эхлээд эдгээр эмх замбараагүй болчихсон байгаа гэрээг цэгцлэх, Биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолыг гаргаж, олон нийтэд зарлаж, хэрэгжүүлэх чиг үүрэг дээр Хүрэлбаатар сайд, Ганбаатар сайд нарын хамтаар ажиллаж байсан. Олон хүний эрх ашиг хөндөгдсөний улмаас өөрийг минь нүүрсчин болгож зарлах энэ ажил хийгдэж явж

байсан гэдгийг хариуцлагатай.../үг тасрав/, яагаад хугацаа дуусаагүй байхад минут минутаар таслаад, энэ гаднын нөлөө ороод байгаа юм биш биз дээ Их Хурлын хэвийн үйл ажиллагаанд? Ингээд улмаар энэ нүүрстэй холбоотой асуудал өнөөдөр энэ Улсын Их Хурлын түвшинд, төрийн түвшинд, олон нийтийн анхаарлын төвд орж ирж байна. Энийг бид маш тодорхой болгох ёстой. Сэжүүрүүдийг уг эзэн дээр нь очих тэр зам хүртэл нь Улсын Их Хурал сонсгол зохион байгуулж хийх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Сүүлдээ хэвлэлээр гүтгэж, гүтгэж байгаад баахан хулгайд холбогдсон мэтээр олон нийтэд ойлгуулж байгаад, огцруулах асуудлыг хүртэл хөндөж тавьдаг болсон. Монгол Улсын Үндсэн хуулиар хүн олгогдсон үндсэн эрхээ эдэлж байх тэр боломжоор хязгаарлах алхмыг хүртэл хийж байгаа юм. Энэ бол дарамт. Энэ бол улсын их, улс төрийн дарамт гэдэг талаасаа энийг харж хандах ёстой. Бямбацогт сайд асуугаад байна. Хэн хэнийг дарамталж байгаа юм бэ гэж байна. Маш олон гишүүдийг дарамталж байна. Олон шалтгаанаар дарамталж байна. Тэгээд энэ бүгдийг гишүүд маань.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Амарбаясгалан дарга үг хэллээ. Дараагийн гишүүн Номин гишүүн, Чинбатын Номин гишүүн микрофон.

Ч.Номин: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би Занданшатар даргыг ажлаа авч байх үед дэмжиж кноп дарсан гишүүний нэг байгаа юм. Яагаад вэ гэхээр би Занданшатар даргыг хүндэлж явдаг, мөн Засгийн газрын тэргүүнээр ажиллах чадвартай хүн гэж боддог байсан. Яг өнөөдрийн байдлаар өмнө нь Занданшатар даргаа бас өөр Засгийн газар, олон Засгийн газрууд өмнө нь байсан. Та энийг мартаж болохгүй. Таны бахархаж яриад, тоог нь ярьж байгаа ярианууд бүгдээрээ 6 дугаар сард гарсан тоонууд буюу өмнөх Засгийн газрын хийж хэрэгжүүлсэн ажлууд байгаа. Мөн өмнөх Засгийн газраас үргэлжлээд ажиллаж байгаа Засгийн газрын гишүүд байгаа. Нөгөө талдаа 3-ыг эсрэг, 3-ыг харьцах 3, дээрээс нь электрон спортын баг гээд эдгээр багуудын гаргаж байгаа амжилтууд Засгийн газарт болон улсад ямар ч яг үнэндээ хамааралгүй. Энэ хүмүүс өөрсдийнхөө бор зүрхээр явж, өөрсдөө энэ авьяас билгээрээ, чадвараараа гарч ирж байгаа гэдгийг би сануулъя гэж бодож байна.

Би яагаад шийдвэрээ өөрчлөх болсон бэ гэхээр, таныг дэмжиж байсан шийдвэрээ би яагаад өөрчилсөн бэ гэхээр 1 дүгээрт Бага хурал дээр гарсан үйл явдлаас болсон. Тэгээд Бага хурлын шийдвэр гарчихсан байхад өнөөдөр бид бүхэн яг үнэндээ сандал судлаа л булаацалдаад байж байгаа шүү дээ. Энэ үнэн. Хөшигний ард болдог байсан зүйл ил болж байна. Харин ч би Монгол Ардын нам маань өөрөө цэвэршиж байна гэж бодож байна. Дарамтлуулж байгаа нь үнэн шүү дээ. Залуу гишүүдийг бүгдийг нь дарамталж байгаа. Энийг нэг их нуугаад байх юм байхгүй. Бүгдээрээ энэ ордны коридороор мэдэж байгаа шүү дээ.

Би Занданшатар дарга, Оюун-Эрдэнэ дарга, Амарбаясгалан дарга гурвуулангаас нь асуумаар байна. Өндөр дээд албан тушаал хашиж байдаг хүмүүс. Энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр яг ямар шийдвэр гарч байж эдгээр гэрээнүүдийг нууцад авдаг юм бэ? Яг шийдвэр нь юу гэж гардаг юм бэ? Би мэдэхгүй учраас асууж байна. Яагаад гэхээр бид энийг үзэж байгаагүй. Тэгэхээр энэ шийдвэр юу байдаг юм бэ гэдгийг хэлээд өгөөч.

2 дугаарт энэ дахиад л Чайна Энержитэй холбоотой асуудлууд гаргаж ирээд л Улсын Их Хурлын гишүүдийг бүгдийг нь худалч болгоод л, бид чинь энийг гаргаж ирээд бүгдээрээ ил болгоод, Улсын Их Хурлаараа хэлэлцээд шийдвэрлэсэн шүү дээ. Энэ яг ямар учиртай юм бэ Оюун-Эрдэнэ даргаа энийг хэлж өгөөч?

Дараагийн нэг юм нь болохоор Занданшатар даргаа таны зөвлөхөөр ажиллаж байгаа залуу энэ дотор сууж байгаа бүх Улсын Их Хурлын гишүүдийг мал гэж доромжилсон. Энд байж байгаа хүмүүс бүгдээрээ бас ч гэж нэг ард түмнийг төлөөлөөд сууж байгаа хүмүүс. Өнөөдөр бид энд орж ирэхдээ паразит болох гэж орж ирээгүй, улс эх орныхоо төлөө ажиллах гэж орж ирсэн. Энэ байдлаас чинь болоод үнэхээр миний танд итгэх итгэл унасан. Тийм учраас би энэ хүсэлт санал дээр гарын үсэг зурсан байгаа гэдгийг хэлье. Би яг энэ утгаараа огцрох ёстой гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Ерөнхий сайд Занданшатар хариулъя.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль зөрчигдөж байна. Зарим гишүүдийн асуулт асуухад минут нь явдаггүй, хариулт өгөх ёстой хүн нь хариулдаггүй, санал гаргасан нэрийдлээр бүх гишүүд хариулдаг. Энэ чинь парламентын мэтгэлцээний бидний оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зарчим биш. Ашиг сонирхлын зөрчилтэй, огцруулах санал гаргасан хүн хурал удирдаж байгаа болохоор ийм дэгтэй явж байна. Үндсэн хууль зөрчигдөж байна гэж үзэж байна.

Манай зөвлөх тийм, одоо энэ сошиалын зөрчил хагаралдаан, хүний нэр устай худлаа үнэн мэдээллүүд дээр итгэж суугаад ийм асуудал ярьж байдаг нь гайхал төрүүлж байна. Би Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг чөлөөлж, томилох саналаа олон нийтэд мэдээлсэн 9 сарын 30-ны өдөр. Энэ бол Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд гаргаж байгаа шийдвэрээ танилцуулж байгаа олон нийтэд танилцуулж байгаа хэлбэр. Процесс дэг харин зөрчигдөөд, одоо хүртэл энэ асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэхгүй байгаа. Энийг хэн нэгнийг яллахын тулд биш, Хууль зүй, дотоод хэргийн сайд бол улсын прокурор ялагч биш, харин нүүрсний энэ сонсголыг зохион байгуулсан мэдээлэлтэй хүн учраас энэ нүүрсний хулгайтай тэмцэх ажлыг бодитой явж, хар цагааныг дэнсэлж, үнэн зөвийг нь олж, нэр төрөө цэвэрлэх боломжийг нь нэгд олгох, нөгөө талаас үнэхээр буруутай бол энэ нүүрсний хулгайтай тэмцэх эдийн засгийн зайлшгүй шаардлага болоод байна.

Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг үндсэндээ нүүрсний эдийн засаг болсон. Нүүрснээс экспортоос бүх зүйл хамааралтай. Тэгтэл тэр нүүрсэнд нь байгаа хулгай зэлгий бүх шатад энэ эдийн засгийг доройтуулж байгаа учраас ийм шийдвэр гаргасан юм. Ийм учраас энэ үндсэн хэрэг дээрээ нүүрийг нь ил болгочхоод, доторх гэрээнүүд нь ил тод болоогүй байсныг Засгийн газар ил тод болгосон. Харин энийг дэнслэх боломжийг олгож байгаа юм. Энэ чинь үнэн мөнийг олох гэж байгаа, бодитой, ил тод болгож байгаа, олон нийтээр хянуулж байгаа ийм бодитой шийдэл. Ил тод байдал бол авлигатай тэмцэх хамгийн зөв шийдэл гэж би үздэг. Ингэж байж юмны үнэн учир олдогдоно, үнэн учир тодорно.

Одоо би хариулах боломж олдсонгүй, Сайнзориг гишүүн гэхэд эдийн засгийн ямар ч ойлголтгүй хүн байна. Эдийн засаг 2,6 хувь болоод уначихсан байсан, одоо

8 дугаар сарын байдлаар 5,7 хувь болоод өссөн гээд наад статистик дээр тэр чинь бичсэн байгаа. 1 их наяд 299, 1,2 их наядын алдагдалтай явж байсан төсөв 8 дугаар сард энэ дүнгээрээ 53 тэрбум төгрөгийн ашигтай гарч, тэр хэмжээгээр энэ алдагдал буурч байгаа юм. Эхний 7 сар ийм их алдагдал үйлдвэрлэчихсэн. 8 дугаар сарын дүнг ярьж байгаа юм. Энэ хоёрыгоо бодитой, баримттай ярих ёстой шүү дээ хуульч хүн, өөрөө бодитой ярья гээд байдаг. Тэр Энержи Ресурс компани энэ тогтоолоос нэг ч төгрөгийн ашиг орлого хүртэхгүй байгаа. Энд тэр компанид хамаараагүй. 25 хувьдаа хүрээгүй тэр чинь. Тэр нүүрс гараагүй гэж хэлж байна. Тэр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут, 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Төрийн өмчийн компаниуд бүгд, төрийн өмчийн компаниуд бүгд 100 хувь биржээр арилжаалж байгаа. Өмнө нь тэгдэггүй байсан. Энэ чинь өмнө байгуулчихсан гэрээнүүд таны тэр 3,4 сая гээд байгаа чинь Чайна энержигийн тэр амнаас борлуулж байгаа амны гэрээтэй нүүрс чинь биржийн арилжаагаар биш гарч байгаа. Энэ чинь өмнө байгуулчихсан гэрээнүүдийн энэ оффтейк гэрээнүүдийн чинь нүүрс гарч байгаа юм. Бүгд тоо баримттай, нотолгоотой ярих ёстой, юмаа судалж байж ярих ёстой. Ийм хийсвэр дүгнэлтээр Засгийн газар огцруулах асуудал оруулж ирсэн чинь та өөрөө харин эрх ашгийн сонирхол, зөрчилтэй байна гэж үзэж байна. 56 хувиар хямд, урт хугацаатай борлуулалттай гэрээний нүүрс чинь ингэж гарч байгаа юм. Биржийн үнээс. Харин биржээр, үнээр чинь 56 хувь илүү өндөр үнээр бид нүүрсээ борлуулж байна. Хамгийн өндөр чанартай нүүрс гаргаж байгаа учраас бид дандаа чулуун нүүрс гаргаж байна. 9 дүгээр сарын дүнгээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Оюун-Эрдэнэ гишүүн нэмэлт хариулт. Асуусан байхаа Номин гишүүн Оюун-Эрдэнэ гишүүнээс? Гурвуулангаас нь асуусан.

Л.Оюун-Эрдэнэ: Ерөнхий сайд энэ Чайна энержитэй холбоотой асуудлыг ярьсан учраас үүн дээр товч тайлбар өгчих нь зүйтэй байх гэж бодож байна. Энэ адармаатай асуудал бас л энэ популизмаас л үүдэлтэй. Анх Монгол ардын хувьсгалт нам эх орны хишиг буюу 1,5 сая төгрөг амласан. Ардчилсан нам эрдэнийн хувь гээд 1 сая төгрөг амласан. Энхбаяр дарга Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихдээ эх орны хишигийг ч өгүүлнэ, эрдэнийн хувийг ч өгүүлнэ ингээд нийлээд 2,5 сая төгрөг болгоно гэсэн. Ингээд иргэддээ 1 сая төгрөг тараах болсон. Энэ ажлын хэсгийг Баярцогт дарга ахалж байсан. Ингээд 1072 хувьцаа гэдэг асуудал үүнээс гарсан. Ингээд Чалкогоос 250 сая ам.долларыг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Амарбаясгалан дарга хариулъя. 1 минут, нэмэлт хариулт. Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Энэ чинь минут богино өгөөд байх юм. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр хуучин 22 оноос өмнө иймэрхүү төрлийн зөвлөмжүүд гарч, ийм аж ахуйн олон ажлыг зөвлөмжөөр халхавчилж нууцад авч хийдэг байсан. Харин энийг энэ нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулаад хуульд өөрчлөлт оруулаад, одоо Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд ямар нэгэн байдлаар ийм аж ахуйн асуудлыг хэлэлцдэггүй болсон. Өмнөх тэр хэлэлцдэг байсан жишиг бол өнөөдөртөө бол байхгүй болсон байгаа.

Мэдээж түрүүн Занданшатар дарга хариулж байсан. Үндэсний хэмжээний том бүтээн байгуулалтуудыг хийх зорилготойгоор зарим зүйлүүдийг Аюулгүйн зөвлөл дээр ярьж, зөвлөмж гаргаж, тэр зөвлөмжийн дагуу энэ бүтээн байгуулалтууд

хийгдсэн гэдэг хариултыг өгч байсан. Бүтээн байгуулалт хийгдсэнийг нь буруутгана гэхээс илүүтэйгээр тэр нууцад авсан үндэслэлээр хямд үнэтэй нүүрсийг их хэмжээгээр авсан асуудлууд нь хөндөгдөж яригдах ёстой болов уу гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Номин гишүүн тодруулъя, 1 минут.

Ч.Номин: Би энэ Чайна энержитэй холбоотой асуултыг тавьсан юм. Энэ коридорт чинь өмнө нь төрийн дээд албан тушаалтай байсан хүн ирээд л өчнөөн их наяд төгрөг, өчнөөн тэрбум долларын асуудлыг гаргаж ирж яриад л, шийдвэр гаргасан Улсын Их Хурлын гишүүдийн нэгдсэн шийдвэрийг худал, дээрээс нь 2 дугаарт хууль бус шийдвэрүүдийг гаргасан гээд ингээд яриад байна. Тэгэхээр яг энэ Чайна энержитэй холбоотой асуудал ямар асуудал болсон юм бэ гэдгийг би дахиад асуучихъя.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах юм бэ? Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Хэдэн минут вэ?

Ц.Сандаг-Очир: Дэгээрээ л 1 минутаараа л хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Тэгэхээр үндсэн асуулт дээр хариулъя, 1 минутаар ийм асуудлыг яаж ярих вэ дээ. Уг нь тэгээд үндсэн асуулт асууж байгаа юм чинь үндсэн асуултад тайлбар хэрэгтэй гэж асуучаад, тэгээд тайлбарлах гэхлээр нэг минут гээд байхаар чинь тайлбарлуулах гээд байна гэж ойлгох уу, үгүй гэж ойлгох уу?

Ц.Сандаг-Очир: Дэгээ л барья. Занданшатар даргын асуултад хариулъя. Чуулганы хуралдааны дэг зөрчигдөөд байна гэж. Энэ тоног төхөөрөмж гацаж байгаа асуудал байна. Энэ бол дэгтэй ямар ч холбоогүй. Гаднаас олон хүмүүс залгаад наад хүмүүсийн яриа юмнууд гацаад байна гэсэн асуудлууд олныг утсаар хэлж байна. Мессеж бичиж байна. Түрүүнээс хойш энэ төхөөрөмжүүдийг Мэдээлэл технологийн албаныхныг дуудаж хэвийн байдлыг ханга гэдэг үүрэг чиглэл өгөөд ингээд ажиллаж байна. Гацаатай байдал одоо хүртэл засагдахгүй байна. Миний энэ хурал удирдаж байгаа компьютер дээр хүртэл асуулт асуусан гишүүдийн асуух гишүүдийн дараалал, нэрс хүртэл алга болчихоод, харин бид энд гараар бичсэн тулдаа ингээд явж байна. Энэ бол чуулганы хуралдааны дэгтэй ямар ч холбоогүй зөрчигдөж байгаа асуудал байхгүй.

Магадгүй зүгээр миний биеийг гарын үсэг зурах, огцруулах дээр гарын үсэг зурсан хүнийг хурал удирдаж байна гэж үзэж байгаа бол энэ нь ямар нэг ашиг сонирхлын зөрчилтэй холбоогүй асуудал. Хурал удирдаж болохгүй гэсэн дэг байхгүй. Тийм учраас хурлаа удирдаад явж байгаа гэдгээ танд хэлье. Дараагийн, танд нэмэлт хариулт байхгүй шүү дээ дэг хариулт? Дараагийн гишүүн. Оюун-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Л.Оюун-Эрдэнэ: Би энэ Чайна энержитэй холбоотой асуудал. Энэ улс төрийн намын 2 даргын ийм зүйл дунд хөрш оронтойгоо байгуулаад Их Хурлаараа бүгдээрээ баталчихсан ийм бараг хориод жил гацчихсан асуудлыг ингэж улс төржүүлж байгаад харамсаж байгаа. Тэгээд Засгийн газрын гишүүд өөрсдөө тайлбарлах бүрэн мэдээлэлтэй мөртөө зориуд ингэж мушгин гуйвуулж, худлаа тайлбарлаад байгаад их харамсаж байгаа.

Энийг 2014 оны 8 сард Элбэгдорж Ерөнхийлөгчийн урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Жиньпин Улаанбаатар хотод ирсэн. Энийг бол Занданшатар дарга мэдэж байгаа, Гадаад хэргийн сайд байсан хүн. Ингээд Хамтарсан тунхаглал гаргасан. Хамтарсан тунхаглалтай хамт гарын үсэг зурагдсан. Энэ нь 2014 оны 8 сард Чайна Энержи групптэй хамтын ажиллагааны.../үг тасрав/, гацаад байна уу? Ингээд 2014 онд ийм гэрээ зурагдчихсан энийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Ингээд яасан бэ гэхлээр 2 асуудал болсон. Нэг нь өргөн, нарийн царигийн маргаан болсон. Ингээд өргөн царигаар барина, үгүй гэдэг ийм асуудал болсон. Дээрээс нь энэ гэрээний ард 2014 онд, 2015 оны 2 сарын 15-ны өдөр энэ гэрээг оруулж ирсэн Их Хурал руу. Энэ дээр тухайн үед Эрдэнэчимэг гишүүн ажлын хэсэг ахлаад, нэг бөөн маргаан болдог энэ тийм ээ, бөөн маргаан болдог энэ.

Энэ дээр Энержи Ресурс компани Тавантолгой лицензийг одоогийн Чайна Энержи группт 30 дээр нэмэх нь 30, 60 жилээр бүх операторынх нь эрхтэй яг Оюу толгойтой адилхан ийм байдлаар өгөх гэрээ хийгдсэн. Ингээд энэнээс болж маргаан болоод, явж, явж байгаад сая бид хамтарсан Засгийн газрын үед Туваан сайд ажлын хэсгийг ахалж байсан Энержи ресурсыг энэ хэлэлцээрээс гаргасан. Ингээд 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болж хувиргасан. Засгийн газрын хэлэлцээр болоод Энержитэй холбоотой асуудлыг энэ тоглоомоос гаргахтай холбоотой улс төр өрнөсөн. Өнөөдөр энэ асуудлууд ингээд яригдаж байгаа нь буцаад Энержийг оруулах гэж байна гэж маш ойлгомжтой уншигдаж байгаа. Тийм учраас энэнтэй холбоотой асуудлыг Их Хурлаар баталчхаад, тэгээд 1 компанийн эрх ашигт бүхэл бүтэн хөрш оронтойгоо хийсэн ийм асуудлаа улс төржүүлж байгаад.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Оюун-Эрдэнэ гишүүний асуултад Ерөнхий сайд Занданшатар, 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Бид хамт ажиллаж байсан хүмүүс, эргээд ч олон жил хамт ажиллах байх. Үнэн л байх хэрэгтэй. Зарим юмнууд дээр санаатай, санамсаргүй алдаад байгаа дээр гайхаж байна. Би 2014 онд Гадаад хэргийн сайд байгаагүй, Улсын Их Хурлын гишүүн ч байгаагүй Си Жиньпин даргыг айлчлах үед.

2 дугаарт би тэр Бодьтой байгуулсан оффтейкийн гэрээ байгуулах үед би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байгаагүй. Энэ 2019 оны 10 дугаар сард байгуулсан юм байна лээ. Би тэр үед Улсын Их Хурлын даргаар ажиллаж байсан. Энэ 46 гэрээг бүгдийг нь ил тод болгож байгаа. Энэ дээр нэг ч Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн гэсэн үг байхгүй. Үндэслэл дээрээ дурдаагүй. Иймээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэж, оффтейк гэрээ байгуулах зөвлөмж гараагүй болохыг энэ Засгийн газрын тогтоолууд өөрөө нотолж байгаа. Энэ 46 гэрээний ил болгосон гэрээнүүд хэзээ, хэзээ хийгдсэн цаг хугацаатай явж байгаа. Энэний 21 нь 22 оноос хойш байгаа. Ийм баримттай, тооцоотой юм ярих хэрэгтэй байгаа 1-д.

2-т өнөөдөр Засгийн газрыг огцруулах үндэслэлд энэ асуудлууд байхгүй. Чайна Энержи, аль эсвэл энэ оффтейк гэрээ. Энийг яагаад асуулт, сэдэв болгоод байгааг би ойлгохгүй байна. Надаас асуулт асуугаад тэр Сайнзориг гишүүн биржийн биш арилжаагаар нүүрс гаргаад байна та нар гэхээр би тэрэнд хийгдсэн гэрээг л хариуг нь хэлсэн. Асуулт ямар байна, би тийм л хариулт өгнө.

Ц.Сандаг-Очир: Оюун-Эрдэнэ гишүүн тодруулга 1 минут.

Л.Оюун-Эрдэнэ: Би баримттай л бас юм ярьж байна шүү дээ. Тэр зөвлөмжтэй холбоотой асуудал тэр чинь юу шүү дээ худалдан авалтаар тендергүй гэдэг ийм л зөвлөмж гаргадаг шүү дээ, тийм биз дээ? Тэгээд тэрэнтэй холбоотой шийдвэр гаргаад л явдаг шүү дээ. Тэрэн дээр мэдэн будилаад байх юу байна вэ? Тэрийг гишүүдэд тэгээд нөгөө ил болгоё гээд байгаа юм чинь тараагаад өгчих л гэж байна шүү дээ. Энэ чуулганаас өмнө, кнопхоос өмнө тэр Бодийн зөвлөмжөө одоо ил болго, ил болгоод гишүүдэд тарааж өг.

Ц.Сандаг-Очир: Цаг ерөөсөө ингээд янз бүрээр гацаад байгаа юм. Харин би тэрийг хэлээд л байна. Одоо яах ёстой вэ? Үгүй ээ, үгүй. Энд секундээрээ дэлгэцэн дээр гарч байгаа юм. Харин яачхаад байгаа юм сүлжээ унагагч тавьчихсан юм уу, яачихсан юм, зүгээр байдаг юм өнөөдөр гэв гэнэтхэн ингээд гацаад, минут юмнууд нь ингээд байгааг би та бүхэнд учирлаад, тайлбарлаад байна. Дараагийн гишүүн Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би 2 асуулт Занданшатар даргаас асуух гээд байгаа юм. Тэгээд тэрнээсээ өмнө хоёрхон зүйлийг хэлээдэхье. Яг энэ уул уурхай болоод энэ хуулийн салбар гэсэн яг 2 салбарыг үндсэндээ энэ улс төрд ёстой хайр найргүй ашигладаг юм байна. Тэгээд энэ 2 салбарыг уг нь ингэж нүдэж байх ёстой салбар ерөөсөө биш. Уул уурхайн салбар ч яах вэ нэг мөнгөтэй юм болохоор ингээд сайд нарынхаа хажууд суугаад ингээд учраа олчихдог юм шиг байна. Манай хууль, хуулийн салбарыг яг энэ улс төрийн ийм асуудалд үнэндээ нээрээ ямар ч үлдэх зүйлгүйгээр шороотой хутгаад дууслаа. Шударга ёсонд итгэх иргэдийн хамгийн сүүлийн итгэл найдвар өөрөө энэ хуулийн салбар байдаг.

Тэгээд би Занданшатар даргаас та энэ олон жил улс төрд байсан хүн учраас хуулийн салбарын сайдыг солихоор яагаад хэрэг шийдэгддэг гэдэг ойлголттой байдаг юм бэ? Үнэхээр энэ олон жил улс төрчид хэргийн хувь заяанд ингэж нөлөөлдөг байсан юм уу нэг?

2 дугаарт хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой асуулт. Яг үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой та яагаад ерөөсөө сэтгүүлчдэд нээлттэй ярилцлага өгөхгүй байгаа вэ гэсэн нэг ийм 2 асуулт байна? Тэгээд хуулийн салбарыг яах юм бэ, цаашид ингээд улс төрдөө ашигласан хэвээрээ байх юм уу?

Ц.Сандаг-Очир: Занданшатар дарга, 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж 3 үндсэн эрх мэдэлд төрийн эрх мэдлийг хуваарилдаг. Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх, хууль биелүүлэх үүрэгтэй субъект. Улсын Их Хурлаас баталсан хуулийг биелүүлэх үүрэгтэй, эрхтэй ийм субъект. Энэ үүргийг Хууль зүй, дотоод хэргийн сайд хэрэгжүүлдэг. Хууль биелүүлэх үүргийг Хууль зүй, дотоод хэргийн сайд хэрэгжүүлдэг. Хууль биелүүлэх үүрэг бол хүний эрхийг хамгаалах ч асуудал байгаа юм. Нөгөө талдаа гэмт хэрэгтэй тэмцэх ч үүрэг байгаа юм.

Өнөөдрийн Монгол Улсын эдийн засгийн хамгийн том сүүдэр бол нийт ард түмний нийгмийн бухимдлаараа харж байгаа сэдэв бол энэ бүх шатанд байгаа хулгай дээрэмтэй эрс шийдэмгий тэмцэхийг бүх судалгаа харуулж шаардаж байна. Энэ Эрдэнэс Тавантолгой дээр 3 сарын хугацаанд онцгой дэглэм тогтоосон

хугацаанд яаж үр ашиг сайжирч болдгийг, гэмт хэрэгтэй тэмцвэл, хулгайг таслан зогсоовол, ил тод байдлыг хангавал яаж эдийн засаг сэргэж болдог юм бэ гэдгийг тоо баримтууд нотолж байна. Тоо худлаа хэлдэггүй. Энэ бол бодит нотолгоо нь. Ийм учраас энэ чиглэлээр хийгдэж байгаа ажлыг улам эрчимжүүлэх нь, харин ч хүмүүст нэр төрөө цэвэрлэх боломжийг олгох нь, харилцан тэнцвэртэй, хяналттай хууль хэрэгжүүлэх Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэх нь Засгийн газрын үүрэг мөн учраас бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг энэ чиглэлээр ажиллуулах ийм шийдлийг гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахаар хүргүүлсэн, одоо хүртэл танилцагдаагүй байна. Энэ бол Ерөнхий сайдын энэ хууль биелүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулж байна гэж би үзэж байгаа юм.

Хэвлэлийн эрх чөлөө ч гэсэн өнөөдрийн бидний хамгийн эмзэг асуудал болсон байна. Нүүрсний байна уу, хулгайн байна уу аливаа мөнгөнөөс ангид, бие даасан эрх чөлөөт хэвлэл мэдээлэл бол ардчилсан засаглалын нэг гол тулгуур багана нь. Ийм учраас бид хэвлэлд нээлттэй мэдээллүүдээ байнга өгч, хамтарч ажиллахыг эрмэлзэж байгаа. Харин хэвлэл мэдээлэл маань бие даасан, хариуцлагатай, тэнцвэртэй байх зарчмаараа ажиллах талаар та бүхний Улсын Их Хурал дээр хэлэлцэж байгаа хууль, тогтоолын төслүүд, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль энэ орчноо сайжруулах бол бидний нэг тулгамдсан асуудал бөгөөд сэтгүүлчдийн эрхийг хамгаалах, хэвлэн мэдээлэх эрхийг нь хамгаалах, сэтгүүлчдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь хамгаалах асуудал бол энэ хуулиар.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баасанжаргал гишүүн тодруулга 1 минут.

Х.Баасанжаргал: Ерөнхий сайдаа би танд Үндсэн хуулийг сануулах нь илүүц байх. Гэхдээ нэгэнт гарсан, үйлдэгдсэн гэмт хэрэгтэй хууль хяналтын байгууллага шүүх эрх мэдэлд тэмцэнэ, Засгийн газар тэмцэхгүй. Энэ чинь Үндсэн хуулийн А үсэг. Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. Дахиж ийм үйлдэл гаргахгүй байхад анхаарна. Тэрнээс Хууль зүйн сайд солигдоод, хэрэг түргэн шуурхай шийдэгддэг гэдэг энэ ойлголт хаана ч, хэзээ ч байж болохгүй. Би нэг их айхтар цэцэн мэргэндээ хэлээд байгаа юм биш, энэ чинь Үндсэн хууль шүү дээ. Би таныг тэгэхдээ арай ч ийм тайлбар өгнө чинээ бодсонгүй. Энэ дээрээ дахиад хариулаарай. Улс төрдөө цаашид дахиад хуулийн салбарыг ингээд ашигласан хэвээрээ байх юм уу та нар? Энд байгаа бүх улс төрч нарт ч гэсэн хамаатай. Цаашид хэнбугай нь ч гэсэн ийм мэдэгдэл хийгээд, ингээд хуулийн салбараар ингээд тоглоод байхыг би бол хувьдаа хэрхэвч тэвчихгүй.

Ц.Сандаг-Очир: 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Хууль зүйн сайд солигдсоноор хэрэг шийддэггүй. Хууль, шүүхийн байгууллага хараат бусаар ажиллах ёстой. Шүүх эрх мэдэлд прокурор хамаарагддаг. Харин гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүрэг Засгийн газарт байдаг. Гудамжинд гэмт хэрэг үйлдэж байгаа хүнтэй тэгээд шүүгч очиж тэмцдэг гэж бодож байна уу? Аль эсвэл хэрэг төвөг гаргаад, авлигал үйлдээд байхаар тэнчээ шүүгч очиж тэмцэх үү? Тэмцдэг хууль сахиулах байгууллагууд, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд байдгийг Үндсэн хуулийн А үсэг та бүхний тангараг өргөсөн Үндсэн хууль дээдлэх зарчимд чинь биччихсэн байгаа шүү дээ. Сайд солигдсоноор хэрэг шийдэгдэнэ гэж бодож байгаа бол энэ Үндсэн хуулийн ойлголтгүй байна гэсэн үг. Хүний эрхийг хамгаалахын тулд прокурор, шүүх байгаа юм. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэгтэй тэмцэх, яллах, цагаатгах.../минут тасрав/

Ц.Сандаг-Очир: Миний бие нэг асуулт асууя, тодруулах юм уу? Нэмэлт 1 Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Цагдаагийн байгууллага хэдийгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байдаг ч гэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд улс төрийн байгууллагын зүгээс нөлөөлөх ямар ч боломж байхгүй. Нөлөөлөх ёсгүй. Энэ чинь ийм маргаан хийгээд, та бид хоёр ийм зүйлийг ингээд яриад сууна гэдэг чинь ичгэвтэр л зүйл баймаар юм. Прокурорын байгууллага нүүрсний хулгайтай холбоотой хэргийн мөрөөр, нүүрсний сонсголын мөрөөр 80 гаруй хэрэгт мөрдөн байцаах шалгалт явуулаад, хэргийг шүүхэд шилжүүлээд, тодорхой этгээдүүд ял шийтгэлээ аваад, одоо 40 гаруй хэргийг шүүх рүү шилжүүлээд гээд ингээд нүүрсний хулгайн мөрөөр хийж байгаа ажлынхаа талаар мэдээллийг олон нийтэд мэдээллийн хэрэгслээр өгсөн байсан.

2 дугаарт та ерөөсөө энэ үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой сэтгүүлчдэд нээлттэй мэдээлэл өгөхгүй байна. Энэнийхээ хариултыг өгөөч? Бид нэг их хайр зарлаад байдаг, тэгсэн хэр нь хайрлахгүй байгаа байхгүй юу жинхэнээсээ.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Дахин хэлэхэд шүүх эрх мэдэлд прокурор хамаардаг бөгөөд прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьдаг субъект хүний эрхийг хангах талаас. Хууль сахиулах ажил бол Засгийн газрын үндсэн үүрэг. Гэмт хэрэгтэй тэмцэх бол. Энэ чиглэлээр холбогдох байгууллагууд мэдээллээ хийж байдаг. Харин энэ улс төрийн өрсөлдөөн тэмцэлдээнүүд чинь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлж байгаа юм. Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд, улс төрийн намын удирдлагууд хэрэг мөрдөн, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Одоо үнэхээр гишүүдийг дарамтлаад байгаа асуудал байвал тэр яриад байгаа гишүүд шүүхэд гомдол гаргах хэрэгтэй шүү дээ. Ингэж байж хууль хэрэгжинэ шүү дээ. Эзэн биегүй юм яримааргүй байна. Тийм учраас бид эзэн биетэй юм ярьж байгаа юм. Олон нийтэд бид байнга нээлттэй мэдээлж байгаа хийж байгаа ажил, Засгийн газрын үйл ажиллагаа. Хэнтэй ч бид чөлөөтэй ярилцахад бэлэн. Өнөөдрийн үйл ажиллагаа ч гэсэн нээлттэй явж байгаа нь бид асуултад хариулж байгаа, иргэдэд мэдээлэл өгч байгаа хэрэг. Гэхдээ Ерөнхий сайд гэдэг хүн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд оролцдог, хэрэг нээдэг, хаадаг, нөлөөлдөг хүн биш. Хууль зүй, дотоод хэргийн сайд ч тийм биш. Энэ тусдаа хуультай. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай дагуу хараат бусаар бие дааж.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 2 асуулт байна. Ерөнхий сайдаа, тийм 23 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Ерөнхий сайдад асар том эрх мэдлийг өгсөн. Энэ нь Засгийн газрын гишүүдээ кабинетаа өөрөө Ерөнхий сайд томилох, чөлөөлөх, огцруулах эрхийг өгсөн. Та 115 хоногийн өмнө үнэхээр авлига, хээл хахууль, хулгайтай тэмцье гэж байсан бол яагаад Энхбаяр сайдыг тухайн, Энхбаяр гишүүнийг яагаад тухайн үед нь Хууль зүйн сайдаар томилж болоогүй юм бэ? Яагаад намын даргын өрсөлдөөн явагдаж байх энэ үед ингэж Энхбаярыг гэв

гэнэтхэн одоо байгаа сайддаа хэлэхгүйгээр нэг өдөр өрөөндөө мэдэгдэл хийж ингэж байгаа юм. Тэгэхээр юу гэж асуух гэж байна вэ гэхээр та мэдэгдэлдээ Амарбаясгалан даргыг нүүрсний хулгайтай холбоотой байсан байна гэж ярьсан. Танд одоо яг Амарбаясгалан дарга нүүрсний хулгайтай холбоотой гэх нотлох, үзүүлэх харуулах баримт байна уу?

Та 5, 6 жил Улсын Их Хурлын дарга хийсэн хүн. Шүүхээр хэн нэгнийг тогтоогоогүй байхад, гэм буруутайг тогтоогоогүй байхад хэнийг ч гэм буруутайд тооцож юу ч болно гэснийг хэнээр ч заалгахгүй мэдэж байгаа. Мэдэхийн дээдээр мэдэж байгаа. Тэгчхээд яагаад Улсын Их Хурлын даргыгаа тогтоолгоогүй байхад нь, ямар ч хэрэг үүсгээгүй байхад нь, ямар ч нотлох баримт цагдаа, прокурор, Авлигатай тэмцэх газар дээр шалгагдаагүй байхад ингэж хэлж байгаа юм бэ? Энэ чинь хууль зүйд нийцэх юм уу? Энэ дээр нэг тайлбар өгөөч. Бортээг гэж, энэ Бортээгийн уурхай чинь яг лиценз нь өнөөдөр хэнд байгаа юм бэ, Амарбаясгалан гэдэг хүнд байгаа юм уу, Админерал гэдэг компанид нь байгаа юм уу? Энэ уурхай энэ чинь хэдэн тонн мянган тонн нүүрсийг гаргачихсан юм бэ? Эндээс Монгол Улс яаж хохирсон юм? Энэ асуултад хариулж өгөөч. Энэ 2 асуултад. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуулийн 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрыг тогтвортой ажиллуулахын тулд Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх эрх мэдлийг Ерөнхий сайдын онцгой бүрэн эрх болгож олгосон юм. Энэ заалтыг хэрэгжүүлэх шаардлага нь тэр үед яагаад 6 сард хийгээгүй гэхээр бид эв нэгдэл зөвшилцлийг баримталж, холбогдох байгууллагуудын хооронд координац хийж, төрийн институтүүдийг тогтвортой ажиллуулах хангахын тулд үндсэндээ бид зөвшилцлийн гэж хэлж болохоор Засгийн газрыг энэ дарга нартайгаа зөвлөлдөж, намын удирдлагын зарчим учраас зөвшилцөж, танхимаа бүрдүүлсэн.

Бортээгийн хувьд Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 63 дугаар тогтоолоор түр хороо байгуулсан. Эрдэнэс Тавантолгой компанитай холбогдох гэрээнүүдийг шалгасан. Тэр үед гудамжинд ямар жагсаал цуглаан болсныг та бүхэн сайн мэдэж байгаа. Энэ хяналтын хүрээ бол Эрдэнэс Тавантолгой компани Hong Kong Hyundai компанийн 2022 оны нүүрс сайжруулсан шахмал түлш арилжих гэрээ, тэр 40 мянга, 400 мянган тонн шахмал хагас коксжих түлш, 100 мянган тонн нунтаг кокс нийлүүлдэг энэ асуудал байсан. Би ганцхан баримт хэлье. Би хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны нарийн нууцыг мэдэхгүй, үзээгүй. Гэхдээ 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Германы нэр бүхий сайт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Амарбаясгалан даргатай холбоотой ноцтой авлигын мэдээлэл цацагдсан. Энэ сайтууд дээр байгаа. Барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бол хэн нэгнийг үндэслэлгүйгээр хүний эрхийг нь зөрчиж, гүтгэж, үндэслэлгүйгээр хэрэгт холбогдуулж тэгж цоллохгүй, цоллодоггүй тийм хэвлэл мэдээллийн хуультай улсууд.

Энэ хэрвээ гүтгэсэн байлаа гэхэд тэгвэл яагаад одоо, энэ тэгээд холбочихсон байгаа биз дээ. Герман, Монголд гарсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарсан мэдээллийг ярихаа больё. Харин баруунд гарсан, хэвлэгдсэн энэ бүх материалуудыг яагаад одоо болтол няцаалт өгөөгүй юм бэ? Энэ чинь Монголд төдийгүй дэлхийд зарлагдчихлаа, энийгээ няцаагаач л гэж байгаа юм. Нэр холбогдлоо л гэж би хэлсэн шүү. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй хэнийг ч гэм буруутайд тооцохгүй гэдэг заалт бол жирийн иргэнийг төрийн дарамтаас

хамгаалсан заалт. Харин төрийн өндөр албан хаагчид бол жирийн иргэд биш, хувь хүн биш, төрийн нэр хүндийг авч байгаа институт субъектүүд учраас хэрвээ нэр холбогдсон бол энийгээ заавал шалгуулж, нэрээ цэвэрлэх ёстой гэж үздэг Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм Улсын Их Хурлаар батлагдсан. Энэ бол төрийн нэр хүндээ хамгаалах шаардлагатай гэсэн Улсын Их Хурлын нэр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Амарбаясгалан дарга, гишүүн хариулт.

Д.Амарбаясгалан: Тагнуулын байгууллагаас гаднын төлбөртэй сайтуудад Монгол Улсаас 50 гаруй мянган доллар төлж байж, олон сайтуудаар нэг дор нэр хүндэд халдах ажиллагаа явуулсан нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон. Хэн энийг хийсэн талаар тагнуулын байгууллага өнөөдрийг хүртэл надад илрүүлэх зүйл дээр удаашралтай ажиллаж байгаа. Энэ бол Монголоос зориудаар нэр хүндэд нь халдах, гаднын сайт дээр мэдээлэл гарсан мэтээр Монголд оруулж ирж цацах зорилготой хийгдсэн ажил гэдэг нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон. Энэ дээр барин тавин ингэж худлаа ярихаа боль. Яаж, хэн, ямар зохион байгуулалтаар хийдэг вэ гэдэг асуудал энд тодорхой харагдаж байгааг олон түмэн эрхээ биш ялгаж салгаж ойлгож байгаа байх гэж бодож байна.

Бортээгийн лицензтэй холбоотой асуудал яригддаг. Өнөөдрийг хүртэл Бортээг гэдэг ордын лиценз Эрдэнэс Тавантолгой компанид байдаг. Гэтэл олон нийтэд надад байгаа юм шиг ойлголт бас төрүүлж гүтгэсэн. Энэ гүжир гүтгэлэг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Би асуултаа нэмж тодруулна. Тэгэхээр Монгол төрийн Засгийн газрын тэргүүн хүн зүгээр барууны хэвлэлд гарсан нэг мэдээллээр асуудалд ингэж хандаж байгаа нь би нотлох баримт байна уу л гэсэн танаас. Тэгээд та бол ярьж байгаа хариултаас чинь нотлох баримт чинь энэ л юм байна. Хэвлэлд гарсан, сайтад гарсан мэдээллээс мэдээлэл аваад Улсын Их Хурлын даргыгаа ингэж гүтгэж болдог юм уу л гэж асуух гэж байна.

Нөгөө талаар оффтейк гэрээ та өнөөдөр, өчигдөр зарлалаа. Энд энэ чинь та ч зарлаж байгаа юм биш 2, 3 жилийн өмнө нүүрсний сонсголын үеэр ил болчихсон асуудал 1-д. 2-т энэ бол нэгхэн хэсэг нь. Энэ ард түмэн мэдэхгүй байна тэр мөнгөн дүнг нь Бодь гэдэг 2 нэрээс өөр. Таны түрүүний хариултаар Баярбаатар гишүүний хариултад маш бөөрөнхий хариулт өгч байна. Одоо бүр эзэн биегүй болох нь л дээ. Тэгээд тэр олон тэрбум долларын үнэтэй нүүрсийг зүгээр хэний шийдвэрээр тэгвэл гадагшаа гаргасан юм бэ? Тийм бага үнийн дүнтэйгээр, тендергүйгээр хэн гаргасан болж таарах вэ таны хариултаар тэр бол. Дундаа хийх гэж байна шүү дээ. Та энэ хариуцлагыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нэг гишүүн байсан хүнийхээ хувьд та энийг мэдэхийн дээдээр сайн мэдэж байгаа. Ингэж таны хариулт бол булзааруулсан бөөрөнхийлсөн хариулт байна гэж би ойлгосон. Ард иргэд юу ч эндээс ойлгохооргүй хариултыг та өгч байна.

Тийм олон тэрбум долларын тийм мянган сая тонн нүүрснүүдийг зүгээр тендергүйгээр өгөх шийдвэртэйгээр тэр нөхдүүд гаргана даа. Одоо тэгээд эзэн биегүй болж дуусах гэж байна шүү дээ. Энэ дээр та тодорхой хариулт өгөөч, битгий бөөрөнхийлөөд байгаач. Таны нотлох баримт зүгээр сайт дээр гарсан мэдээллийг үндэслээд та ингээд ярьж байна гэдэг бол, тэгээд энэ олон гишүүд үнэмшчихсэн өнөөдөр парламентын 67 гишүүн чинь гарын үсгээ зурчихсан, ингээд огцруулах асуудал яригдаад явж байна. Ийм юм байж болдог юм уу? Хариултаа хүсье.

Г.Занданшатар: Таны асуултын хэмжээгээр хариулъя.

Ц.Сандаг-Очир: 5 номерын микрофон 1 минут.

Г.Занданшатар: Олон асуулт учраас 3 минутад хариулъя. 1 дүгээрт би зөвхөн сайтын мэдээлэл хэлээгүй. Нүүрсний сонсголын үеэр Түр хорооноос гаргасан дүгнэлтээр хууль хяналтын байгууллагаар шалгуулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байна. 2 ч нотлох баримттай асуудлаар нүүрсний сонсгол гарсан. Би хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны нууцыг мэдээд энэчээ ярих эрхгүй албан тушаалтан. Та бүхэн хаалттай холбогдох газруудаас бүх мэдээллийг сонсож болно, авч болно. Ер нь энэ нийт төсөвт өртөг нь хийгдсэн ажлууд нь хэдийгээр тэр лиценз төрийн мэдэлд шилжсэн боловч дээр нь баригдсан байгаа үйлдвэр одоо хувийн эзэмшлийнх байгаа шүү дээ. Газар нь төрийн эзэмшилд байвч дээр нь баригдсан.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: 2 дугаарт оффтейкийн гэрээг эзэн биетэй нь ил тод болгочихлоо шүү дээ. Энэ чинь 2 жилийн өмнө зөвхөн нүүр нь ийм гэрээнүүд нь ил тод болсон, доторх нүүрнийх нь ийм гэрээ байгуулсугай гэсэн шийдвэр нь ил тод болсон. Доторх нь алга байна гээд Номтойбаяр гишүүн саяхан хэвлэлийн хурал хийгээд зарлаад байгаа биз дээ, энийгээ ил тод болгооч гээд шаардаад байгаа биз Засгийн газраас. Энэний дагуу энэ 47 гэрээг чинь ил тод болголоо. Тэн дээр хэн гэрээг байгуулсан байгаанууд чинь тодорхой байна шүү дээ. Ямар зөвлөмжийг үндэслэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэсэн гэж байхгүй байна шүү дээ. Тийм байхгүй юмыг би мухар сохроор Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, гэрээн дээрээ биччихсэн байна Засгийн газар байгуулчихсан байна. Нэр бүхий хүмүүсийн гарын үсэг зурсан бүх баримтыг чинь ил тод болгочихлоо. Энэнээс илүү тодорхой хариулт гэж юу байх юм бэ. Энийгээ харин нээлттэй сонсгол хийгээд Их Хурал дээрээ хэлэлц л дээ.

Ц.Сандаг-Очир: Амарбаясгалан дарга нэмэлт 1 минут тайлбар.

Д.Амарбаясгалан: Тагнуулын байгууллагын шинжээчийн дүгнэлт энэ байна. Төлбөртэй, төлбөртэй мэдээлэл тавиулсан Newsdirect гэдэг мэдээллийн сайт байна гэдгийг дүгнэчихсэн. Эзэн бие нь тодорхойгүй байдаг, блокчэйн, магадгүй крипто валютаар төлбөрийг нь явуулдаг, эргээд эзнийг нь олоход хүндрэл үүсгэдэг ийм системийг ашиглаж, миний нэр хүндэд халдсан. Одоо энийгээ Монголд оруулж ирж баримт гэж ярих гэж байгаа бол би энийг хүлээн зөвшөөрөхгүй. Хуулийн байгууллагууд энийг тогтоож өгөх ёстой.

2 дугаарт нүүрсний сонсгол дээр 2 баримтаар тогтоогдсон гэж худал гүтгэлээ та намайг. Надад Авлигатай тэмцэх газар болон цагдаагийн байгууллагаас Админерал гэдэг компанитай ямар нэгэн холбоогүй гэсэн дүгнэлт нь байж байна. Энэ мэтчилэнгээр баримт мэдээллээ нотлохгүйгээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр эрх мэдлээ ашиглаж, хүн гүтгэдгээ одоо зогсоох цаг чинь болсон гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж дууслаа. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Нөгөө дэлгэц дээр нэр нь гарахгүй ингээд. Энэ Мэдээлэл, технологийн албаныхан хурал эхлэхэд л ингээд дэлгэцэн дээр нэр гарахгүй байсан. Баасандорж даргаа энэ хүмүүсээ ажиллуул л даа. Үгүй ээ, өмнө нь зүгээр байдаг байсан, тэгээд яг ийм асуудал хэлэлцэхээр яахаараа ингээд энэ тоног, төхөөрөмжүүд чинь гацаад, саяын улсуудын бараг тал нь хүмүүсийнх нь яриа нь гацаж байна гэнэ, сонсогдохгүй байна гэнэ. Энэ чинь санаатай үйлдэл юм биш үү? Тэгээд одоо яаж нэрээ авах юм бэ? Үг хэлэх гишүүдийн нэрсийг авч дууслаа. 18 гишүүн үг хэлэхээр байна. Баярбаатар гишүүнээр эхэлье. Баярбаатар гишүүн үгээ хэлье.

Б.Баярбаатар: Энэ техникээ нэг шалгуулсан нь дээр байх Тамгын газар. Асуудалтай л болж байх шиг байна ер нь. Асуулт, хариултууд яваад дууслаа. Асуултаас яаж сайхан бултдагийг, бөөрөнхийлдгийг, ярьснаа үгүйсгэдгийг тэгээд бүгд харцгаалаа л даа. Тэгэхдээ нэг юм ойлгоод авлаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тендергүйгээр шалгаруулалт явуулах, худалдан авалт хийх зөвлөмж гаргасан юм байна. Түүн дээр нь үндэслээд энэ оффтейк гэрээнүүд хийгдсэн юм байна гэдэг ойлголтыг бүрэн дүүрэн авлаа. Баярлалаа.

Тэгээд намын асуудлыг төрийн зовлон болгосон нь үнэн. Энэ тэгээд нэг их цагаан байран дээрээ яриад шийдчихсэн асуудлыг нааш нь чирч оруулж ирсэн шүү дээ угаасаа. Тэгээд баахан гүжир гүтгэлэг, нотлогдоогүй баахан зүйлүүд, одоо тэгээд тэрнээсээ буцаад би тэгж хэлээгүй, тийм агуулгаар ярьсан юм. Алуурчин, буцаад нөгөө алуурчин нь тийм зүйл байхгүй гээд л ярьчих юм. Тэгээд ард түмнээр та нар сайхан тоглож байна даа ер нь. Энэ иргэдээр бол зүгээр сайхан тоглож байна. Тэгэхээр нэг ийм хэдэн саналууд байна. Тэр Засгийн газар нь яах вэ дээ тэгээд нэгэнт өргөн бариад явчихсан юм чинь хэлэлцээд л огцорно биз, тэгээд л огцорно уу, байна уу тэрийгээ тэгээд шийдээд л явна биз. Тэгэхдээ уул нь өдий болтол нэг эв нэгдлээ хангаад явчихсан бол энэ тулхтай улс төрийн намын хувьд маш хэрэгтэй л асуудал байгаа юм. Боломж тэгэхдээ нээлттэй л байгаа, тэгээд харж л байя.

Түр хороо байгуулах саналтай байна. Энэ оффтейк гэрээ, тэр Бортээгээр. Энэ түр хороо байгуулж энэ асуудлыг мухарлах ёстой. Түрүүн та хариулж байхдаа юу гэххэв, бараг энийг яагаад эртхэн ингээд мэдээлж байхгүй яасан юм бэ гэсэн чинь эв нэгдлийг хангаад гээд хариулчих шиг болно лээ шүү дээ. Хууль бус юмыг эв нэгдлийн ард нуусан чинь л асуудал байна шүү дээ тэгвэл. Жилийн өмнө, жил хагасын өмнө энэ Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан гэдэг хүн чинь бүрэн эрх ч үгүй нам дээрээ ерөнхий нарийн бичгийн дарга хийгээд сууж байсан шүү дээ. Тэр үед нь барьж аваад шалгахгүй яасан юм бэ? Тэгээд одоо нэг ийм байж боломгүй зүйлүүд гаргаж ирж тавьчхаад л, тэрийгээ үнэн мэт ингээд дүр төрхөнд орж яриад, иргэдийн тархийг угаагаад байх шаардлага байхгүй.

Тэгэхээр энэ улс төрийн намуудаас энэ хамтарч энэ Түр хороо байгуулах шаардлагыг би энэ саналыг энэ Их Хурлын даргад тавьж байна. Яаралтай бүүр. Энэнээс бид салахгүй, энийг мухарлаж байж дуусна, үнэн мөнийг олж байж бид энийг хойш нь тавина гэж бодож байгаа. Нэгэнт ийм байдал би үүсчихсэн юм чинь одоо энийг тэгээд эвлэж нэгдсэн байлаа ч гэсэн энийг явуулах ёстой. Үнэн мөнийг олох ёстой. Тэгэхээр гишүүд саналуудаа хэлээд, би яаралтай санал хураалтаа явуулмаар байна гэж бодож байна Байнгын хороон даргаа. Засгийн газрын энэ огцрох, огцрохгүй асуудал дээр энэ шийдлүүдээ гаргаад явахгүй бол энэ гадаа жагсаж байгаа хүмүүсээ хар, энэ багш нараа хар, эмч нараа хар, энэ өвөлжилт

хүндрэх аймгуудаа хар, төсвөө хар. Сандал суудлын энэ нэг энэ асуудлаа ер нь тэгээд цэг тавьсан нь дээр байх, хурдан хэлэлцээд дуусгая гэсэн саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Баавартай байна, хүчтэй байна, та нар хуулиа уншаач гэж дээрэнгүй л хэлж байна. Уг нь уншаад л байгаа байхгүй юу. Өөрийнх нь хэлсэн үгэн дээр нь үндэслэж уг нь хэлээд л байгаа юм. Үндсэн хуулийн 39.4 Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна гэж байгаа. Мөнхбаатар сайд хөөрхий амьтан мэдэгдлээсээ огцорсныгоо мэдсэн гэж байгаа. Ёс зүйн дүрэм гэсэн гишүүдийн ёс зүйн дүрэм 3.2.Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэлтэй хандах, бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх, доромжлохыг цээрлэнэ., 3.8.Гишүүн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхдээ албан ёсны эх сурвалжийг баримтлах ба олон нийтийг төөрөгдүүлэх үндэслэлгүй мэдээлэл хийхийг хориглоно. Яах вэ Занданшатар дарга маань Улсын Их Хурлын гишүүн биш учраас танд үйлчлэхгүй л байх. Гэхдээ бусад гишүүд маань ямар эх үүсвэр дээр суурилж, ямар мэдээлэл хийгээд байгааг би сайн ойлгохгүй байна.

Нөгөө олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудаар, хэрэгслүүдээр гарсан нөгөө төлбөрт мэдээн дээр нь суурилад яваад байгаа юм уу? Нэвтрүүлэгт хүртэл ороод Энхбаяр Амарбаясгалан хүн алчихсан гэсэн биз дээ, хэлсэн шүү дээ, хүн болгон сонссон биз дээ. Би буруу сонсоод, би буруу, худлаа яриад байгаа юм уу. Тэгээд гишүүд жоохон ёс зүйтэй баймаар байна. Тэгээд л жагсаалтын хэд гээд дээрэлхэх юм, шинэ гишүүд 1А-гийнхан гээд л дээрэлхэх юм. Дүү нар жоохон замбараатай бай, эрэмбэ дараатай бай л гэх юм. Үгүй ээ ах нар хэдэн жил ингэж яваад ингээд сурчихсан, үүнийгээ ингээд хүчиндээд яваад байдаг юм бэ? Төсвийн тодотголоосоо авхуулаад буруу л явсан шүү дээ. Төрийн албан хаагчдыг яаж хуурч мэхэлж, ямар заалтуудыг оруулж, яах гэж явлаа. Алт 3 хөтөлбөрийн тогтоол ч гэсэн яаж гарлаа. Дандаа ингээд нэг хооронд нь мангартуулаад л бүүр нэг аргалаад сурчихсан ийм байж болдог юм уу.

Ямар азаар 126 гишүүнтэй болсон юм, ямар азаар анх удаа сонгогдсон 80 гаруй гишүүнтэй байгаа юм, ямар азаар залуу гишүүд маш ихээр орж ирсэн юм, ямар азаар нийгмийн төлөөллүүд сайн орж ирсэн юм, ямар азаар барьцаанд орох гишүүд ийм бага хэмжээнд байгаа юм бэ л гэж бодож байна. Үнэн, цагаан байран дээр яримаар байна. Удирдах зөвлөл яагаад хуралдахгүй байгаа юм бэ, яагаад Бага хурлын 321 гишүүний гаргасан саналыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм бэ? Яагаад өрсөлдөөнөө цагаан байран дээрээ, нам дээрээ хийхгүй Төрийн ордонд авчирч завааруулаад байгаа юм бэ. Би ч сүүлдээ нүүрсчин боллоо. Үгүй ээ, залхаж байна шүү дээ. Энэ хэлбэрээр хэдий урт хугацаанд явах юм бэ?

Тэгээд төсөв, муу төсөв өргөн барьсан шүү дээ. Заавал намын дарга байж байж л төсвөө авч гарна гэдэг чинь бас яадаг юм бол доо. Мууг бол муугаар нь л хэлнэ шүү дээ. Аймгийн аль ч Засаг даргатай одоо ярихад аймгуудын төсөв орохгүй байгаа шүү дээ. Тэтгэвэртээ гарч байгаа төрийн албан хаагчдын 36 сарын тэтгэмж бүүр өнөөдөр өгөгдөхгүй байгаа шүү дээ. Хүнд байгаа. Тэгээд зүгээр аргалаад чи юу мэддэг юм, хуулиа унш гээд сууж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Ийм ч учраас Сайнзоригийн болон бусад гишүүдийн хамтаар Засгийн газар огцрох нь зүйтэй гэдэг гарын үсгээ зурсан болно. Бид үүнийг засах ёстой.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Ингээд хэлэлцүүлэг хариултуудыг олон нийт харж байгаа байх. Би намын байран дээр буюу Тусгаар тогтнолын ордон дээр болсон үйл явдал, тэр өрсөлдөөнт байдал, ардчилал, институт болгон дээр байдаг тэр өрсөлдөөний үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй энд чирч орж ирээд, төрийн зовлон болгож байгаа энэ асуудал дээр хуулийн хүрээнд болоод, улс төрийн хүрээнд шийдэх гарц нь Ерөнхий сайдыг огцруулах юм байна гэдэг үүднээс л өнөөдрийн асуудлыг хөндөж байгаа. Өөр юм алга.

Тэгээд энэ албан тушаалтайгаа зууралдах хугацаандаа аймшигтай юм байна. Би бүр үнэхээр доромжлуулж, гүтгүүлэх асуудал бүр хэрээс хэтэрсэн. Өнөөдөр Ардчилсан намын гишүүн Монголхүү гээд залуу чамайг энэ материалыг Дамдинням сайд чинь гөвөөд өг гээд өгсөн шүү гээд твиттер дээр над руу биччихсэн. Тэгээд ил тод байна лээ шүү дээ. Тэгээд манай Дамдинням арай тэгээгүй байх гэж би итгэж байгаа. Уг нь ажил хийх гээд зүтгээд байгаа юм шиг мөртөө ерөөсөө аргаа олохгүй л байна л даа. Тэгээд би бас уул уурхайд бүгд энэ эдийн засаг тогтож байгааг бид ойлгоод байгаа байхгүй юу. Би энэ компаниудад буруу биш. Тийм учраас энэ асуудлыг нь зөв болгож өгөх ёстой.

Түрүүн Бямбацогт сайд зөв асуулт асуусан юм бодитой байх ёстой гээд. Бодитой байх ёстой. Тэгэхдээ энийг нь аваачаад хууль зөрчөөд шийдвэр гаргаж өгч болохгүй байхгүй юу. Энэнээсээ парламентаасаа асуугаад, хуулийг нь өөрчлөөд, дагаж мөрдөх журмын зохицуулалтыг нь хийж байгаад, Засгийн газар 4 сар 10 хоногийн хугацаатай шийдвэр гаргаж болохгүй. Дээрээс нь Амнат-ийн аргачлалыг, 5 хувийг өөрчлөөгүй боловч аргачлалыг нь өөрчилж байгаад ингэж улсын төсөв дээр орох ёстой орлогыг бүрдүүлж тасалдуулж болохгүй. Өмнөх шийдвэр нь хүчин төгөлдөр байж байхад дахиж давхардуулж шийдвэр гаргаж болохгүй. Энэ татварын байцаагч чинь аль журмаар нь, аль аргачлалаар нь одоо татвараа тавих юм бэ? Дараа нь энэ албан хаагчид чинь дуудагдана шүү дээ.

Өнөөдөр Занданшатар дарга намайг эдийн засаг мэдэхгүй гэж байх шиг байна. Та нуугаад хэлүүлэхгүй байгаа юм байна лээ. 8 сарын байдлаар 1,2 их наяд төгрөгийн төсвийн алдагдалтай байгаа юм байна лээ шүү 8 сарын 30-ны байдлаар. Өнөөдөр яах вэ нэг сар хугацаа байгаа. Энэ аяндаа гарна Занданшатар дарга. Одоо ингэж энийг аргалах гэж хэлээд хэрэггүй. Энэ өнөөдрийн байдлаар чинь орох ёстой Амнат-ийн төлөвлөгөөнөөс 15 тэрбум төгрөг тасарчихсан байгаа юм байна лээ. 2 тэрбум төгрөгийг нь энэ журмаас болоод нэгхэн компанийн асуудал болчихсон байгаа шүү гэх жишээний юмнуудыг яриад байвал ярьж болно. Нийт улсын дүнгээрээ энэ бол бараг 200 тэрбумаас дээшээ юмнууд үүсэхийг үгүйсгэхгүй. Тэгэхдээ өнөөдөр яах вэ би бол Сангийн яам энэ аргалаад л, кабинетын зарчим гээд зогсож байгаа юм л даа. Би одоо тэгээд яах вэ.

Хамгийн гол нь хуульт ёс гэдэг зүйлүүдийг ингэж алдагдуулж болохгүй. Бид хуулийн хүрээнд, зарчмын хүрээнд Монгол Улсын иргэдийн эрх ашгийг баримталж энэ шийдвэрүүдийг гаргана. Уул уурхайн компаниа бодолцолгүй яах вэ. Тэгэхдээ ингэж хууль зөрчиж, 100 хувь биржээр зар гэснийг 25 хувиар зарчхаад, 75 хувийг нь бусад буюу биржийн бус байдлаар зар гэж хэлж болохгүй. Тэгээд 25 хувийг нь биржээр зарчхаад хямд үнээр, цаашаа өөр үнээр зарсан 75 хувиа 25 хувьтай дүйцүүлээд татвар төл, энэ бол ёстой гоёмсог шийдвэр гэж хэлж болохгүй. Тэгэхээр ийм зүйлүүд үнэхээр байна. Тэгээд энийг уг нь зогсоочих байсан юм даа. Би уг нь

Дамдинням сайдад хэлсэн. Энэ асуудал оройтоогүй дээр засчхаач. Тэгээд өнөөдөр яг энэ журам гарсны дараа нүүрс борлуулах гэрээнүүд 85, 100-аараа зурагдаж байгаа юм байна лээ. Цаасан дээр зурагдаж байгаа. Яагаад гэхээр энэ чинь цонх үеийг ашиглаад баахан цаасан дээр нүүрс борлуулж аваад, тээвэрлэлт байхгүй гэсэн үг шүү дээ. Энэ чинь дараа жил болон дараа, дараа жилийн улсын төсөв дээр ерөөсөө өмнөх жилийн нүүрсийг гаргасаар байгаад л дуусах юм байна лээ. Ерөөсөө бид хэд ийм юм руугаа л явж байгаа юм. Харамсалтай байгаа.

Тэгээд яах вэ Үндсэн хуулийн суурь зарчмаа бол би хамгаална. Энэ парламентын засаглал Үндсэн хууль руу жижгээр халдана гэж ойлголт байхгүй. Улс төрийн зорилгодоо хууль хяналтын байгууллага, манай хууль зүйн салбарыг битгий ингэж шившигтэй байдлаар хутгаач. Энэ салбар чинь ерөөсөө улс төрийн гар хөл юм байна гэдэг л ойлголт авчихлаа шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн, Саранчулуун гишүүн үгээ хэлье.

О.Саранчулуун: Байнгын хорооны эрхэм гишүүддээ оройн мэндийг хүргэе. Өнөөдөр манай улс төрд хүлээн зөвшөөрөгдөнө гэдэг нь бусдыг гүтгэж, сүрдүүлж, гутаан доромжлуулж, буруутгахыг хэлдэг юм уу гэж би асуумаар байгаа. Улс төрийн туршлага гэж ер нь юу юм бэ, бусдыгаа хэр харлуулж байгаа, хэнийг айлгаж гутаасан он жилүүдийн чинь нийлбэр юм уу? Тэрүүгээр та нар улс төрийн туршлагатай гэж ярьдаг юм уу?

Уг нь миний ойлгож байгаагаар нийгмийн амьдралд өөрчлөлт, ахиц авчирсан туршлага байх ёстой биш үү. Би ойлгохдоо иргэдийн эв нэгдэл, итгэлийг авч, хариуцлагатай, шударга ёсыг сахиулж байж улс төрийнхөө олонхоор хүлээн зөвшөөрөгдөнө гэж ойлгож л өөрөө энд явж байгаа. Сангийн сайдаа та Монгол Улсын статистикийг хардаг уу? Монголд өнөөдөр өвдөөгүй айл, ядарсан, зовсон хамаатангүй гэр бүл гэж байгаа юу? Дэлхийд юугаараа дээгүүр байна Монгол Улс хавдраараа, амиа хорлолтоороо, өвчнөөрөө л дээгүүр байна. Ийм удаан Засгийн газарт ингэж он удаан жил ажилласан юм бол яагаад, улс төрийн туршлагатай юм бол, ах юм бол яагаад эд нарыгаа засаж залруулахгүй байгаа юм бэ? Яагаад залруулъя гэж ороод ирсэн бидний бодлогыг дэмжихгүй байгаа юм бэ?

Ядарсан иргэдийн асуудлыг шийдэх болохоор дургүйд хүчгүй гэдэг шиг яасан өөдгүй юм бэ та нар. Та нар гадаа жагсаж байгаа хүмүүсийг гэнэт нэг өдөр гарч ирээд жагсаж байгаа гэж боддог уу? Энэ чинь олон жил, сарын том, жижиг асуудал нийлээд аргаа бараад гарч ирж байгаа юм. Би та бүхнийг, би яагаад энд нэгдэж байгаа гэхлээр эрүүл мэндийн салбарт урьдчилан сэргийлэх бодлогоо дэмжинэ гэж зөндөө хөтөлбөр дээрээ ярьсан мөртөө үйлдлээр хийгээгүйн чинь төлөө, халамж авагчид гэж ядарсан хүмүүст эд нар халамж авч байна гэж мөнгийг нь ярьж бамбай хийдэг хэр нь яг тэд нарыг хөгжүүлэх хөтөлбөр ярихаар дэмжээгүйн чинь төлөө, боловсролын салбарт бүгдийг тэгш хамруулах боломжийг ярьдаг мөртөө өнгөн дээрээ тунхаглана, үйлдэл дээрээ анхаардаггүйн чинь төлөө, дээрээс нь энэ бүхний алдааг засаадхаач гэж жагсаалтад биднийг оруулж 23 оны 5 сарын 31-нд Үндсэн хуулийнхаа өөрчлөлтөөр, өөрсдийнхөө нэрээр төлөөлөл гэж оруулчхаад, оруулсан бодлогыг нь сонсдоггүй, дэмждэггүй, ярих болохоор өөр аргаар ярих гэдэг ийм хайхрамжгүй хандлагын чинь төлөө би өнөөдөр энэ дээр ингээд сууж байгаа.

Ирээдүйд над шиг олон хүмүүс улс төрийн эрхээ эдэлж, зүй ёсны оролцоогоор нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүсэж байгаа. Гэтэл ийм

аргыг зааж үлгэрлэх юм уу? Тэгвэл яах гэж энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж ингэж явж байгаа юм бэ? Яагаад би өнөөдөр энд орчхоод нүүрсчин болоод сошиалаар янз бүрээр доромжлуулаад сууж байгаа юм. Өмнөх засгийнхаа алдааг засаад, хараагүйг харж, хүний эрхийн төлөө гэсэн хэр нь үйлдэл дээрээ яагаад хийхгүй байгаа юм бэ? Тийм учраас миний ард байгаа олон мянган хүний өмнөөс би энэ Засгийн газар ажлаа хийхгүй байна гэж үзэж байна. Мэдэхгүй байгаа байх гэж би урьд нь боддог байсан. Үгүй юм байна, мэддэг юм байна, сэтгэл гаргадаггүй юм байна.

Цаашдаа би энэ зарчмаа үргэлж ярих болно. Хэн ч засгийн эрхийг авч, хэн ч ажилласан би энийгээ үргэлж шаардана. Ганцхан багана мөрний асуудал, ганцхан санхүүгийн төлөвлөгөөний асуудлуудыг би ярьж байгаа шүү дээ. Тэгээд асуухлаар яагаад яасан ийм үл хайхарсан, ямар сонин сэтгэлгүй юм бэ? Яг надтай адилхан дэлбэрч байгаа хүмүүс энд зөндөө байгаа. Тийм болохоор ядарсан ахмадууд биеэ өвтгөн барин өнөөдөр зогсож байгаа шүү дээ. Энэ бол ганцхан миний дуу хоолой биш, миний ард өчнөөн олон хүмүүс байгаа, та нарын амьдралдаа ч хараагүй, мэдэхгүй хүмүүс зөндөө байгаа. Яагаад тэд нарын дуу хоолойг ярих гэж энд орж ирчхээд би өнөөдөр ийм юманд сууж байгаа юм бэ? Энэ тэнэг хэрүүлийг чинь сонсоод сууж байгаа юм. 10, 20 жил улс төрд байхдаа юу хийсэн юм бэ тэгвэл.

Ц.Сандаг-Очир: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Эрхэм гишүүддээ оройн мэнд хүргэе. 1 дүгээрт Сайнзориг гишүүнээ би яалаа гэж тийм мангар юм хийгээд явж байх вэ дээ. Та бас итгэж байгаа байлгүй дээ. Яах вэ энэ Амнат-тай холбоотой тогтоол бол улс төржөөд л үсрээд ороод ирчихсэн байгаа юм. Зүгээр ний нуугүй хэлэхэд өмнө нь энэ 55 дугаар тогтоол 2025 оны 55 дугаар тогтоол гарахаас өмнө манай улсын Засгийн газар 9 удаа Амнат-ийн тогтоолыг өөрчилж гаргаж байсан. Энэ нь дандаа нүүрсний үнэтэй холбоотойгоор л хөдөлж байсан байдаг юм. Нүүрсний үнэ унахаар зэрэг эх үүсвэрээ доошлуулаад л, нүүрсний үнэ өсөхөөр зэрэг жишиг үнэ рүү аваачаад савлаад байдаг. Тэгээд энэ жилийн тухайд ялгаагүй, нүүрсний үнэ бараг 50 хувь унасан, энэнээс шалтгаалаад 10 дахь тогтоол гарсан. Бүүр гэрээний үнээр буюу татвараас шууд 100 хувь зугтаах боломжтой тогтоолыг 3 ч удаа гаргасан байдаг юм. Энэ 10 удаагийн 3-д нь.

Манай Сайнзориг гишүүн Хууль зүйн яаманд тэнд ажиллаж байхдаа энийг бүтэн сайн мэдэж байгаа байх. 13 оноос хойш уул уурхайн салбарыг хариуцсан мэргэжилтэн, газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга байсан хүн аягүй сайн мэдэж байгаа байх. Ашигт малтмалын тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрх байдаг юм 47.6.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална. 47.14.Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана гэж байгаа юм. Түрүүн Сангийн сайд бид бол хуулиараа л явсан. Хуулиа, хуулийн дагуу л байгаа. Асуудлыг шалгана биз.

Түрүүн Сангийн сайд дэмжээгүй л гээд байна лээ. 2025 оны 8 сарын 19-ний 01 77 72 бичгээр дэмжсэн, энэ байна. 2025 оны 7 сарын 29-ний 1/ 556 дугаар бичгээр Хууль зүйн сайд энэ дэмжихсэн байна. Та бас засгийн үйл ажиллагаанд оролцож байсан хүн мэдэж байгаа байх. Хууль, ямарваа нэг тогтоол засагт орохын тулд

ерөөсөө ерөөсөө заавал Сангийн сайд, Хууль зүйн сайд нар зөвшөөрч байж ордог шүү дээ, зөвшөөрөөд л орчихсон юм. Амнат-ийг биржээр тооцно гэдэг өөрөө ил тод болгож байгаа юм. Ил тод болгож байгаа юм. Энэ урт хугацаатай том гэрээнүүдээс 56 хувийн илүү үнээр авч байгаа юм шүү. Түрүүн нэг компанийн нэр яриад байх шиг байна лээ Энержи ресурс гээд. Тэр компани энэ тогтоолоор давуу тал авч байгаа юм алга. Яагаад вэ гэвэл энэ компанийн экспорт 25 хувьдаа хүрээгүй байгаа. Өөрөөр хэлбэл сар болгон тооцдог Амнат-аас 6, 7, 8 сар, 9 сар ингээд авахад энэ компани эндээс ямар ч хөнгөлөлт авахгүй.

Биржийн арилжааны 86 хувь нь төрийн өмчит хувьцаат компаниуд байгаа. 100 хувь бирж дээр зарж байгаа, ил болгочихсон. Тэгээд бид дуудлага худалдаагаар үндсэндээ 10 төгрөг, 100 төгрөг гэж байгаа юмыг өрсөлдөж ингэж өссөөр байгаад нэг 10-аас 20 хувь өсдөг юм. Энэнийхээ үр дүнд жилийн эцэст 130 тэрбум төгрөг олно. Энэ маягаараа ингээд явбал бид 1 их наядын орлого олох ёстой байсан бол 1 их наяд 359 тэрбум төгрөгийн орлого олох юм. Ийм л тогтоол баталсан. Тэгээд яах вэ би танд түрүүн дээр хэлж байсан буруу, зөв ойлголт байгаа бол хэдүүлээ тэгээд тэр шалгадаг газраар нь шалгуулчихна биз дээ. Улс төр болгож, Засаг огцрох хэмжээний асуудал энд ерөөсөө байхгүй шүү дээ.

Тэгээд та бид хоёрын дэвшсэн нам Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт чинь аж ахуйн нэгжүүдийн дарамтыг бууруулна гэсэн байгаа. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд ч хүртэл экспортын бараа, бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг сайжруулна гэсэн заалтууд байгаа. Тэр хуультай, дүрэмтэй, өмнө нь хийгдэж байсан жишигтэй бүтэн ийм л юм байгаа юм. Тэгээд зүгээр ний нуугүй хэлэхэд Засгийн газрыг огцруулах асуудлаа бол энэ хоолоо олж идэж байгаа салбараа самарчхалгүйгээр оруулаад ирчихгүй дээ л гэж харж байгаа шүү дээ. Тийм л байна даа.

Ц.Сандаг-Очир: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үгээ хэлье.

Х.Баасанжаргал: 3 минут тийм ээ. Бид ер нь нэг засаглал хуваарилах онол шүүх эрх мэдэл, хууль, гүйцэтгэх эрх мэдлийн 3 ийм салаа мөчиртэй гэж ер нь бүгдээрээ дандаа худлаа л ярьдаг юм байна л даа. Зүгээр ярьдаг л юм байна. Хэзээ ч манай шүүх эрх мэдлийн байгууллага төсвөө тануулахгүйгээр төсвөө батлуулж үзээгүй шүү дээ. Сангийн сайдаас мөнгө гуйгаагүй нэг ч жил байхгүй шүү дээ. Анх удаагаа өнгөрсөн жил байшин шүүхийн барилга гэдгийг бариулж үзэж байгаа шүү дээ энэ 30 жилд. Тэгээд та нар бүгдээрээ худлаа ярьдаг байхгүй юу. Тэгээд яг нэг өнгөн дээрээ ингээд нэг гоё хэвлэл мэдээллийн эрх чөлөөгөө ярина, тэгсэн хэр нь мэдээллээ өгөхгүй. Шүүх эрх мэдлийн байгууллага бие даасан, хараат бус байх ёстой гэнэ. Тэгсэн хэр нь энэ хэргийг шалгуулахын тулд сайдыг нь солино гэж ярина. Ингээд яг нэг ийм бараг л нэг байран дээр ингээд 2 өөр юм ярих юм. Тэгээд мэдээж энэ нээлттэй явж байгаа. Манай бусад улс төрчид ч гэсэн эндээс сургамж аваасай гэж бодож байна.

2 дугаарт Хэрлэн гишүүн гээд ингээд нэр бүхий гишүүд энэ материалтай урьдчилж танилцъя гэдэг шаардлага тавилаа. Бид хэсэг нэр бүхий гишүүд өнгөрсөн хаврын чуулганаар бид энэ ер нь материалтай урьдчилж танилцдаг баймаар байна, яг ирээд сандалд суулаа, ширээн дээр материал ирдэг баймааргүй байна, бид танилцдаг баймаар байна гээд бичгээр шаардлага хүргүүлж байсан. Тухайн үед дэмжээгүй шүү дээ. Энэ туршлагатай, улс төрийн туршлагатай гишүүдээс нэг нь ч дэмжээгүй шүү дээ. Бараг та нар юу яриад байгаа юм, юу нэхээд байгаа юм л гэсэн.

Энд бүх тоглоомын дүрэм өөрчлөгдмөөр байна. Та нар энэ юм өөрчлөгдөж байгаа гэдгийг ингээд нэг ийм хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Цаг үе өөрчлөгдөж байна. Хүмүүсийн хүсэн хүлээж байгаа зүйл өөрчлөгдөж байна. Өөрчлөлт гараасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Засгийн газар, төрийн ажил үр дүнтэй байгаасай гэж хүсэж байна.

Өнгөрсөн 5 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны үр дүн, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг гишүүдэд өгсөн. Харамсалтай нь тэнд хүний хөгжлийг үнэлэх индекс үзүүлэлт нэг ч шалгуур үзүүлэлт байхгүй учраас хүний хөгжлийн бодлогын талаар бид дүгнэлт гаргаж чадахгүй нь гэдэг хариу ирсэн. Үгүй ээ, тэгээд ийм л байна шүү дээ. Тэгсэн мөртөө хүний хөгжлийн мега төсөл гээд. Яагаад ингээд худлаа ярьдаг юм 5 алхахгүй. Би энэнээс цаашаа өчнөөн олон жил амьдарна. Би ингэж худлаа ярьдаг ийм газар байгаадаа заримдаа нээрээ яг Саранчулуун гишүүнтэй адилхан мэдрэмж үнэхээр төрж байна. Эсвэл ингээд та нар ингээд ерөөсөө ингээд ширлэчихсэн байдаг юм уу, шир гэж эсвэл энийг хэлдэг юм уу, мэдэхгүй бүр үнэхээр ёстой бүр заримдаа хэлэх үг олдохгүй юм.

Дамдинням гишүүн саяхан өчигдөр байна уу, уржигдар бензиний талаар мэдээлэл тараасан, худал мэдээлэл тараасан иргэдийг тагнуулын байгууллагаас шалгана гээд л мэдээлэл тавьсан. Яагаад ингэж иргэдээ дарамтлаад байгаа юм. Үнэн шүү дээ, бензин тасалдаад байгаа шүү дээ, колонкууд очертой байгаа шүү дээ, иргэд бүгдээрээ л хэлж байгаа шүү дээ. Тэгээд бүгдийг нь тагнуул шалгаад зогсоочих юм уу? Тийм, ингэж ерөөсөө бүх юмыг ингээд дарамтлаад, хүчээр шийднэ гэдэг энэ бүх юм бүгд өөрчлөгдөж байгаа ах нараа. Бид ийм зүйлийг зүгээр хүлцэн тэвчээд өнгөрүүлж чадахгүй. Бүх зүйл өөрчлөгдөж байгаа гэдгийг л та нар маань нэг ойлгоод, та нар эсвэл өөрчлөгд, эсвэл зайгаа тавь, өөр сонголт байхгүй шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн үгээ хэлье.

Э.Одбаяр: Энэ Байнгын хорооны хэлэлцүүлэг, хуралдааны явцыг олон нийт харж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд юуны өмнө олон нийтээсээ хүлцэл өчиж байна. Ингээд төрийн эрх дээд байгууллагын хуралдааны танхимыг шүүх хурлын заал болгож, хэн хамгийн их хулгай хийх вэ гэдэг улсын уралдаан зарлаад, тэрнийхээ ялагчийг цагаан байрандаа тодруулж чадахгүй, Төрийн ордонд оруулж ирээд, манай намын хэдэн гишүүдийг ингээд нэг олны хэсэгтээ ингээд иргэдийн төлөөлөл юм шиг суулгаад, ингээд хулгайгаа ярьж байгаад, тэгээд өдийд арай өөр зүйл яригдах ёстой, цаг хугацааны хувьд ч. Тэгээд энийг тоох нэг ч эрүүл ухаантай хүн энэ Монгол Ардын нам дотор үлдээгүй байна гэдгийг би ойлгож байна.

Занданшатар даргыг анх би томилогдоход нь би хэлж байсан. Та парламентын ёсыг төрт ёсыг үгүйсгэж, Ерөнхий сайд нэр дэвшиж байгаа учраас таныг би дэмжихгүй гэдэг байр сууриа илэрхийлж байсан. Тэр байр сууриа би одоо хамгаалж байгаа. Яагаад гэхээр 126 парламентын гишүүн төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон, ядаж энэ гүйцэтгэх засаглалын тэргүүн нь эндээсээ байгаасай гэж би бодсон.

2-т би Амарбаясгалан даргыг би парламентыг удирдаж байгаа хүний хувьд энэ яригдаж байгаа, хэлэгдэж байгаа зүйлүүдээ нэг тийш нь болтол бас энэ парламент ёсныхоо төлөө алхам хийгээсэй гэж би бодож байна. Намаа самарчихсан та хэд маань, одоо төрийг самармааргүй байна. Тэгээд азаар Монгол Ардын намын олон дарга нар энэ танхимд сууж байгааг далимдуулаад нэг үг

хэлчихье. Та нар үе үеийн манай намын лидер, туг болсон сүнс ах нарыг энэ ардчилсан хувьсгалыг хийсэн ах нарыг буудаж, доромжилж, гүтгэж, хилсээр шоронд хийж, хил гартал нь дарамталж олон сонгуулийн ард гарсан шүү. Одоо та хэд албан ёсоор уучлалт гуйгаарай. Ямар ч үед манай намынхан хийе, бүтээе гэж явдаг, алддаг, асгадаг, хийж бүтээж байгаа хүмүүс. Гэхдээ та нар шиг ингэж өдөр, шөнөгүй хулгай ярьж, хэлэлцүүлэг хийдэггүй шүү.

Харин ийм нөхцөлд орж ирсэнд ямар ч муу юманд нэг тийм сайн тал байдаг гэдэг шиг олон их наядын хулгайг чинь олон нийт харах боломж бүрдэж байгаад их талархаж байна. Энэ бол парламентын үнэт зүйл гэж би ойлгож байна. Тэгээд дарга нараа энэ шүүх хурлаа шүүх дээрээ юм уу, эсвэл цагаан байран дээрээ очиж хийгээд, энэ олон нийтийг нэг тархи толгойг нь цэвэрлээд, энэ ордонд байгаа сэтгүүлчдийг 2 хувааж талцуулахаа болиод, ажлаа хиймээр байна. Огцрох ёстой дарга нар нь бүгдээрээ огцоръё. Энэ Төрийн ордон бол та нарын өмч биш шүү. Бид олон намын тогтолцоотой парламентын улсад байгаа. Ард түмний мандат авсан Их Хурлын гишүүд. Зөвхөн танай намынхан дураараа дургидаг тийм зарчим энэ ордон дотор байхгүй. Тэгээд хэрүүлээ хол очиж хий, бүгдээрээ огцор.

Ц.Сандаг-Очир: Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Уучлаарай Одбаяр гишүүнээ, энд нэг их хулгай хийчхээд, хулгайчаараа дуудуулаад сууж байх сонирхол алга байна. Би хэлж байгаа. Өнөөдрийг хүртэл надтай холбоотой олон гүжир гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулалттайгаар асар их мөнгө зарж явууллаа. Улс төрч өрсөлдөгчөө намнадаг ийм арга хэлбэр байдгийг би өнөөдрийг хүртэл мэдэхгүй явж ирлээ. Өөрийн бие дээр тохиолдохоор аргагүй ойлгодог юм байна. Хууль хяналтын байгууллага, улс төрийн дарамт, дарангуйлал гэж юу байдаг юм бэ гэдгийг ойлгож мэдэрч байна.

Миний хувьд энэ парламентын ардчиллыг дэмжих, парламент дахь улс төрийн намуудын оролцоог бодитой бий болгох, парламентад байгаа улс төрийн намууд нь институт байж, бодлогын өрсөлдөөнийг хийдэг, улс орны өнөөдрийн, маргаашийн хөгжлийг бодлого болгож төлөвлөж чаддаг байх тэр түвшинд хүрэх ёстой л гэсэн зорилгоор ажиллаж ирсэн. Түрүүн Занданшатар дарга хэлж байна гадаадын сайт гээд. Германд бүртгэлтэй мөртөө хаана байдаг нь тодорхойгүй хуурамч сайт мэдээлэл дамжуулдаг хэрэгсэлд 50 гаруй мянган доллар төлж, 37 сайтаар намайг гүтгүүлсэн. Тагнуулын байгууллагад гаргасан гомдлын дагуу тагнуулын байгууллагын шинжээч ийм хуурамч сайтаар мэдээллийг гүтгэж, түгээж тараасан байна гэдэг энэ шинжээчийн дүгнэлтийг гаргаж надад ирүүлсэн.

Ахиад Админерал гэнэ үү, Бортээг гэнэ үү миний мэдэхгүй, миний оролцоогүй, надад огтоос байгаагүй, цаашдаа ч байхгүй тэдгээр зүйлүүдээр намайг гүтгэсэн. Энэ асуудлаар би Сонгинохайрхан дүүргийн шүүхэд хандаж, намайг гүтгэсэн мэдээллийн сайттай шүүхдэлцэж, ялалт байгуулсан, тогтоогдоогүй. Энэ мэтчилэнгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төрд халдаад, араас нь ажил албан тушаалаасаа огцор гэдэг гүжир гүтгэлгийг, шаардлагыг тавьж явж байгааг би гайхаж байгаа. Би ардчилсан Монгол Улсын иргэн гэж өөрийгөө бодож явдаг, 21 дүгээр зуунд амьдарч байгаа иргэн гэж бодож явдаг. Буруугүйгээ нотол гэдэг байдлаар шаарддаг. Огт шалгагдаагүй хэргээр өөрийгөө буруугүй гэдгээ нотол гэдэг ийм шаардлагыг тавьдаг энэ нийгэм 21 дүгээр зуунд биш гэж би боддог. 1937 онд байсан бол магадгүй гаргаж аваачаад буудчихмаар байх шиг байгаа юм.

Бид харин өнөөдөр парламентын засаглалтай, ардчилсан нийгэмд амьдарч байгаа гэдгээрээ бахархаж, тэрийгээ бэхжүүлэхийн төлөө ажиллаж, амьдарч байх ёстой гэж бодож явдаг. Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн үзэл санаанд хүний үндсэн эрхэд гэм буруутай гэдэг нь аль нэг шүүхийн байгууллагаар тогтоогдоогүй хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй гэсэн Үндсэн хуулийн суурь зарчим байж байдаг. Гэтэл ямарваа нэгэн хуулийн байгууллагад шалгагдаагүй намайг, аливаа шатны шүүхийн байгууллагаар таслагдаагүй намайг гэм буруутай гэж үзэж, өнөөдөр огцор гэдэг шаардлага тавьж явж байгаа улс төрийн энэ үйлдлээсээ ичих хэрэгтэй. Би тогтоогдсон бол энд би юм ярихгүй, би ёс суртахууны хариуцлагаа хүлээгээд, асуудалд би нээлттэй хандаад явах эр зориг, итгэл үнэмшил, ёс суртахуун надад хангалттай байгаа.

Харамсалтай нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр яллаж байгаад, чи албан тушаалаасаа чөлөөлөгдөж шалгуул гэдэг зүйл 21 дүгээр зууны ардчилсан Монгол Улсад байхгүй зарчмаар намайг шахаж байгаа учраас би энд дуугаа өргөнө гэж бодож байгаа юм. Бид нэг хүний удирдлагатай нийгэм биш шүү дээ. Бид нэг хүний удирдлагаар хууль хяналтын байгууллага нь ажиллаж, хэн нэгнийг улс төрийн ялтан болгодог энэ нийгэмд бид амьдраагүй гэдгийг бид дандаа бодож байх ёстой. Энэ бол харамсалтай байна. Өнөөдөр бид ичих хэрэгтэй. Ард иргэд маань, залуу үе маань ийм зүйл байдаг юм гэдгийг сонсоод, хараад сууж байгаагаас бид ичих ёстой. Харин бид илүү тэдний амьдрах орчин.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдээ 18 цаг болсон байна, ажлын цаг дууссан байна. Тийм учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйл буюу Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг гэж заасан байна. 13.1.9-д илтгэл, танилцуулга сонсох, асуулт, хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах цагийг тогтоох эрхтэй гэж хуралдаан даргалагчийн эрхийг заасан байна. Энэ 13.1.9-ийг үндэслээд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг ирэх даваа гарагийн 13-ны өдрийн 11 цаг хүртэл хойшлуулахаар шийдвэрлэлээ. 1 дэх өдөр үг хэлэх улсууд энэ ирцээрээ, энэ дарааллаараа үгээ хэлээд явна.

Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дууслаа. Нээлттэй байгаа шүү, 1 дэх өдөр үргэлжлээд явна.

18.03 цаг

Хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11 цаг 05 минутаас үргэлжлэв.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны 2025 оны 10 сарын 13-ны 11 цагаас товлогдсон байгаа. 11 цаг болсон байна. Өмнөх ирцээрээ явна. Өмнөх хуралд ирээгүй байсан гишүүд нэмэгдэж ирцдээ орж болно. Мөн 5 дахь өдөр ирцэд орсон хэр нь өнөөдөр албан ёсны гадаад томилолттой байгаа мэр сэр гишүүд байгаа юм байна. Чөлөө хүссэн гишүүд байгаа юм байна. Тийм учраас энэ улсуудыг ирцээс хассан нь дээр, хасах ёстой байх. Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Оюунсайханы Алтангэрэл гишүүн Ерөнхийлөгчийн айлчлалтай 10 сарын 13-наас 16-ны хооронд ирцээс гаргая. Нямтайширын Номтойбаяр гишүүн мөн адилхан Ерөнхийлөгчийн айлчлалд 10 сарын 13-наас 10 сарын 16-нд албан ёсоор чөлөө хүссэн учраас ирцээс хасаж өгөхийг хүссэн хүсэлтийг үндэслэж, өнөөдрийн ирцээс хасъя. Бусад гишүүд

гайгүй байх. Энэ Амгаланбаатарын Ганбаатар гишүүн өвчтэй юм уу? Угаасаа ирцэд ороогүй байгаа юу?

Бусад гишүүд хуралдаандаа орж ирэхийг хүсэж байна. Асуулт дууссан байгаа, одоо үг хэлэх гишүүд үгээ хэлнэ. 10 гишүүн үг хэлэхээр нэрсээ өгсөн байгаа. Болдын Жавхлан гишүүнээр үг хэлэх эхэлнэ, үргэлжилнэ. Хэлэлцэх асуудал үргэлжилж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг Сайнзориг нарын 54 гишүүнээс гаргасан энэ асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Гишүүдийг ажлын албаныхан дуудаарай. Энэ хажуу талд Ардчилсан намын бүлэг хуралдаад, хуралдаан нь дуусаагүй байх шиг байна тийм үү? Хэлээрэй гишүүдэд нь.

Ирцдээ ороогүй гишүүд, өмнөх хуралдаан дээр ирээгүй байсан гишүүд нэмж орж ирэхийг хүсэж байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүдийг, Амгаланбаатарын Ганбаатар гишүүдийг хуралдаандаа ирэхийг хүсэж байна.

Алив энэ ажлын албаныхан гишүүд рүүгээ залгаарай. Энэ ирцэд орсон гишүүд яачхав. Одоогийн байдлаар Зулпхар гишүүн, Бямбацогт гишүүн 2 орж ирсэн байна. Үг хэлэх Жавхлан гишүүн сууж байна. Бусад гишүүд, өөр гишүүд аль нь ч байхгүй байна. Дуудаарай. Хэрлэн гишүүн орж ирж байна.

Гишүүдээ дуудаарай. Энэ гишүүд орж ирэхгүй байна. Бадамсүрэн гишүүн орж ирсэн байна. Яачхав, 20 минут өнгөрлөө. Хэрвээ 30 минут хүртэл хүлээгээд орж ирэхгүй бол хуралдааныг хаалаа.

Эрхэм гишүүд ээ, Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал 11 цагаас товлөгдсөн хурал 11 цаг 30 минут болж байна. Одоогийн байдлаар 5, 6-хан гишүүн ирсэн байна. Ардчилсан намын бүлэг хуралдаад дуусаагүй байгаа юм байна. Тэгээд Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам, Эвсэл гээд хэнийг нь ч хэн гэлтгүй үнэхээр хариуцлагагүй байна шүү. Чухал асуудал хэлэлцэх гэж байхад хуралдаандаа өмнө нь ирсэн ирцээрээ эхлэх гэхээр 4, 5-хан гишүүн ирчхээд байдаг. 4, 5-уулаа сууж байгаад ямар хуралдалтай биш, 30 минут хүлээлээ. Ингэж төрийн ажлыг гацааж, ингэж тээг саад болж байгаа бол үнэхээр хариуцлагагүй байна. Хэнийг нь хэн гэлтгүй.

Энэ бол Үндсэн хуулийн хугацаатай ажил. Үндсэн хуулиар заачихсан хугацаатай ажил. Тэгээд төрийн ажлыг ингэж бойкотолж гэдэг юм уу ирцээр, энийг чинь ард түмэн харж байгаа шүү, хариуцлагагүй байна шүү. Тэгье. Би ирсэн гишүүдийг нь зарлая. Тийм. Манай Байнгын хорооны гишүүдээс Хэрлэн гишүүн ирсэн байна, Сайнзориг гишүүн ирсэн байна, Сайнзориг гишүүн чинь биш, Бямбацогт гишүүн орж ирээд гараад явсан, Даваасүрэн гишүүн орж ирээд гараад явсан, Зулпхар гишүүн ирсэн, Бадамсүрэн гишүүн ирсэн. Байнгын хорооны биш гишүүдээс Сайнзориг гишүүн, Жавхлан гишүүн 2 ирсэн байна.

Ингээд яг Байнгын хорооны гишүүний ирсэн 4, 5 гишүүн л байна. Ирцдээ орсон. Ирц бол 32 юу, 22-оороо явж байгаа, 20-оос явж байгаа, Номтойбаяр гишүүн, Алтангэрэл 2 гишүүн албан ёсоор гадаадад томилолттой байгаа учраас ирцээс хассан. Тэглээ гээд ирц хангалттай байгаа. Тэгээд одоо дөрвүүлээ, тавуулаа ингээд өөд өөдөөсөө харж сууж байгаад хэндээ, юугаа хэлэх вэ дээ. Ардчилсан намын

бүлэг 10 цагаас эхэлсэн хурал нь одоогоор дуусаагүй байна. Ардчилсан намын бүлгийн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн нэг нь ч орж ирээгүй байна. ХҮН намаас нэг нь ч орж ирээгүй байна.

35 минут хүлээлээ, ирэхгүй байгаа учраас өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг хаалаа. Жич хуралдааны товыг тогтоож, зар хүргэж, хуралдааныг хуралдуулна. Хэлэлцэх асуудал хэвээрээ. Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг хаалаа.

2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11 цаг 33 минут.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА